Таних тэмдэг, масштаб ашиглан тодорхой талбайн тойм зураг үйлддэг /бүтээлээр үнэлэх/	- Тойм зургийн агуулгыг нэрлэдэг - Байр зүйн зургийн таних тэмдгээс хамааралтайг нь сонгож хэрэглэдэг	- Тойм зургийн агуулгыг нэрлэдэг - Байр зүйн зургийн таних тэмдгээс хамааралтайг нь сонгож хэрэглэдэг - Масштаб ашиглан зайг тодорхойлдог	- Тойм зургийн агуулгыг нэрлэдэг - Байр зүйн зургийн таних тэмдгээс хамааралтайг нь сонгож хэрэглэдэг - Масштаб ашиглан зайг тодорхойлдог 4 зүг, 8 зовхисоор зүг чигийг нэрлэдэг	- Тойм зургийн агуулгыг тодорхойлдог - Байр зүйн зургийн таних тэмдгээс хамааралтайг нь сонгож хэрэглэдэг - Масштаб ашиглан зайг тодорхойлж, масштабын гурван хэлбэрээр нэрлэж тэмдэглэдэг 4 зүг, 8 зовхисоор зүг чигийг нэрлэдэг

Суралцахуйн үр дүн:

7.1.2. Сурагч нарны аймгийн бүдүүвч ашиглан гарагуудын байрлал, хэмжээг харьцуулдаг, цагийн ялгааг тооцоолж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Нарны аймгийн бүдүүвч ашиглан дэлхий болон бусад гарагуудын байрлал, хэмжээг харьцуулдаг	- Нарны аймгийн бүдүүвч ашиглан гарагуудын байрлалыг нарнаас алслагдсан дарааллаар нь эрэмбэлдэг - Нарны аймгийн гарагуудын хэмжээг хүснэгтэн мэдээнд тулгуурлан нэрлэдэг	- Нарны аймгийн бүдүүвч ашиглан гарагуудын байрлалыг нарнаас алслагдсан дарааллаар нь эрэмбэлдэг - Нарны аймгийн гарагуудын хэмжээг хүснэгтэн мэдээнд тулгуурлан дүрсэлдэг	- Нарны аймгийн бүдүүвч ашиглан гарагуудын байрлалыг нарнаас алслагдсан дарааллаар нь эрэмбэлдэг - Нарны аймгийн гарагуудын хэмжээг хүснэгтэн мэдээнд тулгуурлан их/багаар нь харьцуулдаг	- Нарны аймгийн бүдүүвч ашиглан гарагуудын байрлалыг нарнаас алслагдсан дарааллаар нь эрэмбэлдэг - Нарны аймгийн гарагуудын хэмжээг хүснэгтэн мэдээнд тулгуурлан их/багаар нь харьцуулдаг (хамгийн хол, хамгийн ойр, хамгийн том, хамгийн жижиг, хамгийн их дагуултай, хамгийн цөөн дагуултай)
2. Газар орны цагийн ялгааг тооцоолдог	Эх сурвалжид тулгуурлаж зарим улс орнуудын цагийн бүсийг тооцоолдог	- Өдөр эхлэх шугам ба цагийн бүсийн эхлэл шугамын үүргийг тодорхойлдог - Эх сурвалжид тулгуурлаж зарим улс орнуудын цагийн бүсийг тооцоолдог	- Өдөр эхлэх шугам ба цагийн бүсийн эхлэл шугамын үүргийг тодорхойлж, дэлхийн тэнхлэгээ эргэх хөдөлгөөнтэй холбон дүрсэлдэг - Эх сурвалжид тулгуурлаж зарим улс орнуудын цагийн бүсийг тооцоолдог	- Өдөр эхлэх шугам ба цагийн бүсийн эхлэл шугамын үүргийг тодорхойлж, дэлхийн тэнхлэгээ эргэх хөдөлгөөнтэй холбон тайлбарладаг - Улс орнуудын цагийн бүсийг уртрагийн зөрүүд тулгуурлан тооцоолдог

1.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ДЭЛХИЙН ГАДАРГА

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна:	1. Газрын гадаргын хотгор гүдгэр хэлбэрийг зурган мэдээлэл ашиглан харьцуулдаг
	7.2.1. гадаргын хэлбэрийн ялгаатай байдлыг харьцуулан, бүрэлдэн тогтоход нөлөөлөх хүчин зүйлсийг хялбар туршилтаар үзүүлж шалтгааныг	2. Гадаргын хэлбэр бүрэлдэн тогтоход нөлөөлдөг гадаад ба дотоод хүчин зүйлсийг ялган ангилдаг
		3. Гадаргын хотгор гүдгэр хэлбэр бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг хялбар туршилтаар үзүүлж, шалтгааныг тайлбарладаг

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

7.2.1. Сурагч гадаргын хэлбэрийн ялгаатай байдлыг харьцуулан, бүрэлдэн тогтоход нөлөөлөх хүчин зүйлсийг хялбар туршилтаар үзүүлж шалтгааныг тайлбарлаж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Газрын гадаргын хотгор гүдгэр хэлбэрийг зурган мэдээлэл ашиглан харьцуулдаг	- Газар зүйн зургийг уншдаг - Газрын гадаргын хотгор гүдгэр хэлбэрийг нэрлэдэг	- Газар зүйн зургийг уншдаг - Газрын гадаргын хотгор гүдгэр хэлбэрийг ялгадаг - Тухайн газар орны газар зүйн зургаас гадаргын хэв шинжийг тодорхойлдог	- Зурган мэдээлэл болон газар зүйн зургийг ялган уншдаг - Газрын гадаргын хотгор гүдгэр хэлбэрийг ялгадаг - Тухайн газар орны газар зүйн зургаас гадаргын хэв шинжийг тодорхойлдог	- Зурган мэдээлэл болон газар зүйн зургийг ялган уншдаг - Газрын гадаргын хотгор гүдгэр хэлбэрийг ялгадаг - Хоёр ба түүнээс дээш өгөгдсөн газар орныг газар зүйн зургаас олж гадаргын хэв шинжийг харьцуулдаг
2. Гадаргын хэлбэр бүрэлдэн тогтоход нөлөөлдөг гадаад ба дотоод хүчин зүйлсийг ялган ангилдаг	Дэлхийн дотоод хүчин зүйлсийг ялган нэрлэдэг (тектоникийн хавтангийн хөдөлгөөн г.м.)	- Дэлхийн дотоод хүчин зүйлсийг ялган нэрлэдэг /тектоникийн хавтангийн хөдөлгөөн/ - Дэлхийн гадаад хүчнийг ялган нэрлэдэг /нар, хур тунадас, салхи, хүн, амьтны нөлөө/	- Дэлхийн дотоод хүчин зүйлсийг ялган нэрлэдэг /тектоникийн хавтангийн хөдөлгөөн/ - Дотоод хүчин зүйлсээс хамааралтай гадаад илэрлүүдийг ялган нэрлэдэг /газар хөдлөлт, галт уулс/ - Дэлхийн гадаад хүчнийг ялган нэрлэдэг /нар, хур тунадас, салхи, хүн, амьтны нөлөө/	- Дэлхийн дотоод хүчин зүйлсийг ялган нэрлэдэг /тектоникийн хавтангийн хөдөлгөөн/ - Дотоод хүчин зүйлсээс хамааралтай гадаад илэрлүүдийг ялган нэрлэдэг /газар хөдлөлт, галт уулс/ - Дэлхийн гадаад хүчнийг ялган нэрлэдэг /нар, хур тунадас, салхи, хүн, амьтны нөлөө/ - Гадаад хүчний нөлөөний үр дагаврыг ялгадаг /чулуулгийн элэгдэл, өгөршил, усаар зөөгдөх/
3. Гадаргын хотгор гүдгэр хэлбэр бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг хялбар туршилтаар үзүүлж, шалтгааныг тайлбарладаг	Гадаргын гүдгэр хэлбэр бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг газар хөдлөлттэй холбон нэрлэдэг	Гадаргын гүдгэр хэлбэр бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг газар хөдлөлт, галт уулшил, нар, салхи, усны үйл ажиллагаатай холбон нэрлэдэг	Гадаргын гүдгэр хэлбэр бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг газар хөдлөлт, галт уулшил, нар, салхи, усны үйл ажиллагаатай холбон уулыг төрөл, хэлбэрээр нь ялган дүрсэлдэг	Гадаргын гүдгэр хэлбэр бүрэлдэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг газар хөдлөлт, галт уулшил, нар, салхи, усны үйл ажиллагаатай холбон уулыг төрөл, хэлбэрээр нь ялган тайлбарладаг

1.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. ДЭЛХИЙН УУР АМЬСГАЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 7.3.1. тодорхой газар орны цаг агаарын төлөв байдлын мэдээллийг харьцуулан өөрчлөлтийг нь	1. Цаг агаар ба уур амьсгалын ялгаа, бүрдүүлэгч элементүүдийг ялган, газар орны цаг агаарын төлвийг 7 хүртэлх хоногийн цаг агаарын мэдээнд тулгуурлан өөрчлөлтийг нь тодорхойлдог
2	Сурагч ... харьцуулж чаддаг болсон байна: 7.3.2. газар зүйн зураг болон бусад мэдээлэлд тулгуурлан газар орнуудын уур амьсгалын ерөнхий төрх байдлыг тодорхойлж, ялгааг нь	1. Хүснэгтэн мэдээг ашиглан уур амьсгалын (температур, хур тунадас) график байгуулдаг 2. Газар зүйн зураг болон уур амьсгалын график ашиглан газар орнуудын уур амьсгалын ерөнхий төрх байдлыг тодорхойлж, ялгааг нь харьцуулдаг.

Суралцахуйн үр дүн:

7.3.1. Сурагч тодорхой газар орны цаг агаарын төлөв байдлын мэдээллийг харьцуулан өөрчлөлтийг нь тодорхойлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Цаг агаар ба уур амьсгалын ялгаа, бүрдүүлэгч элементүүдийг ялган, газар орны цаг агаарын төлвийг 7 хүртэлх хоногийн цаг агаарын мэдээнд тулгуурлан өөрчлөлтийг нь тодорхойлдог	- Температурын зөрүү, хоногийн их, бага температур, хур тунадас, гийгүүлэх хугацаа, салхины чиглэл, агаарын даралт аль нэгийг нэрлэдэг боловч цаг агаар, уур амьсгалын ялгааг гаргахгүй байх - Мэдээллийн хэрэгслээс газар орны цаг агаарын 7 хүртэлх хоногийн мэдээг өдөр ба шөнийн температур, салхины үзүүлэлтүүдээр нь ялган тэмдэглэдэг	- Уур амьсгал гэдэгт: Олон жилийн дундаж үзүүлэлт учраас температур, хур тунадас, салхины зонхилох чиглэл, агаарын даралт, нар гийгүүлэх хугацаа зэргийг хамруулах. - Цаг агаар гэдэгт: хоногийн температурын зөрүү, хоногийн их, бага температур, хур тунадас, гийгүүлэх хугацаа, салхины чиглэл, агаарын даралт аль нэгийг нэрлэдэг - Мэдээллийн хэрэгслээс газар орны цаг агаарын 7 хүртэлх хоногийн мэдээг өдөр ба шөнийн температур, салхи, нар гийгүүлэх хугацаа, хур тунадасны үзүүлэлтүүдээр нь ялган тэмдэглэдэг	- Цаг агаар эсвэл уур амьсгал гэдгийг тодорхойлдог боловч (Уур амьсгал гэдэгт: Олон жилийн дундаж үзүүлэлт учраас температур, хур тунадас, салхины зонхилох чиглэл, агаарын даралт, нар гийгүүлэх хугацаа зэргийг хамруулах. - Цаг агаар гэдэгт: хоногийн температурын зөрүү, хоногийн их, бага температур, хур тунадас, гийгүүлэх хугацаа, салхины чиглэл, агаарын даралт) аль нэгийг нэрлэдэг - Мэдээллийн хэрэгслээс газар орны цаг агаарын 7 хүртэлх хоногийн мэдээг өдөр ба шөнийн температур, салхи, нар гийгүүлэх хугацаа, хур тунадасны үзүүлэлтүүдээр нь ялган тэмдэглэдэг - Ялган тэмдэглэсэн мэдээллээ хэрхэн өөрчлөгдөж байгааг нь харьцуулдаг /өмнөх өдрөөсөө, дараагийн өдөр нь температур хэрхэн өөрчлөгдсөн болох г.м./	- Цаг агаар ба уур амьсгалын ялгааг тодорхойлдог. (Уур амьсгал гэдэгт: Олон жилийн дундаж үзүүлэлт учраас температур, хур тунадас, салхины зонхилох чиглэл, агаарын даралт, нар гийгүүлэх хугацаа зэргийг хамруулах. Цаг агаар гэдэгт: хоногийн температурын зөрүү, хоногийн их, бага температур, хур тунадас, гийгүүлэх хугацаа, салхины чиглэл, агаарын даралт, чийг) - Мэдээллийн хэрэгслээс газар орны цаг агаарын 7 хүртэлх хоногийн мэдээг өдөр ба шөнийн температур, салхи, нар гийгүүлэх хугацаа, хур тунадасны үзүүлэлтүүдээр нь ялган тэмдэглэдэг - Ялган тэмдэглэсэн мэдээллээ хэрхэн өөрчлөгдөж байгааг нь харьцуулдаг /өмнөх өдрөөсөө, дараагийн өдөр нь температур хэрхэн өөрчлөгдсөн болох г.м./ - Өдөр шөнө, эсвэл хамгийн их, бага өөрчлөлт байгаа үеийг тодорхойлдог

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

7.3.2. Сурагч газар зүйн зураг болон бусад мэдээлэлд тулгуурлан газар орнуудын уур амьсгалын ерөнхий төрх байдлыг тодорхойлж, ялгааг нь харьцуулж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Хүснэгтэн мэдээг ашиглан уур амьсгалын (температур, хур тунадас) график байгуулдаг	Өгөгдсөн газар орны уур амьсгалын үзүүлэлт бүхий хүснэгтэн мэдээллийг ашиглан температурын график байгуулдаг (Хүснэгтэд өгөгдсөн тоон утгуудыг шууд Х:У тэнхлэгт бичиж (5, 6, 8, 11, 15 г.м.), график байгуулсан)	Өгөгдсөн газар орны уур амьсгалын үзүүлэлт бүхий хүснэгтэн эсвэл зурган мэдээллийг ашиглан температурын график байгуулдаг (Х:У тэнхлэгт хамаарах тоон утгыг (5, 10, 15, 20 г.м.), саруудыг (I, II, III г.м.) оновчтой байршуулсан)	Өгөгдсөн газар орны уур амьсгалын үзүүлэлт бүхий хүснэгтэн болон зурган мэдээллийг ашиглан температур, хур тундасны 2 ялгаатай үзүүлэлтээр хоёр тусдаа график байгуулдаг (Х:У тэнхлэгт хамаарах тоон утгыг (5, 10, 15, 20 г.м.), саруудыг (I, II, III г.м.) оновчтой байршуулсан)	Өгөгдсөн газар орны уур амьсгалын үзүүлэлт бүхий хүснэгтэн болон зурган мэдээллийг ашиглан температур, хур тунадасны 2 ялгаатай үзүүлэлтээр нэг график байгуулдаг (Х:У тэнхлэгт хамаарах тоон утгыг (5, 10, 15, 20 г.м.), саруудыг (I, II, III г.м.) оновчтой байршуулсан)
2. Газар зүйн зураг болон уур амьсгалын график ашиглан газар орнуудын уур амьсгалын ерөнхий төрх байдлыг тодорхойлж, ялгааг нь харьцуулдаг	Өгөгдсөн газар орны уур амьсгалын графикаас уур амьсгалын ерөнхий төрх байдлыг нэрлэдэг (хүйтэн, сэрүүн халуун)	Өгөгдсөн газар орны уур амьсгалын графикаас уур амьсгалын ерөнхий төрх байдлыг дүрсэлдэг (хүйтэн, сэрүүн халуун)	- Өгөгдсөн газар орны уур амьсгалын графикаас уур амьсгалын ерөнхий төрх байдлыг тодорхойлдог (хүйтэн, сэрүүн, халуун) - Хоёр ба түүнээс олон газар орны уур амьсгалыг мэдээллийг харьцуулж, ялгааг нь нэрлэдэг	- Өгөгдсөн газар орны уур амьсгалын графикаас уур амьсгалын ерөнхий төрх байдлыг тодорхойлдог (хүйтэн, сэрүүн, дулаан, халуун, халуун чийглэг, халуун хуурай г.м.) - Хоёр ба түүнээс олон газар орны уур амьсгалын мэдээллийг харьцуулж, ялгааг нь тодорхойлдог

1.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. ДЭЛХИЙН УС

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 7.4.1. усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг ялган	1. Усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг усны төлөвд үндэслэн ялган тодорхойлдог
2	Сурагч ... ялгаж чаддаг болсон байна: 7.4.2. дэлхийн далайн хэсгүүдийг	1. Дэлхийн далайн хэсгүүдийг ялган, хүйтэн ба дулаан урсгалыг газар зүйн зураг ашиглан нэрлэдэг
3	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 7.4.3. хуурай газрын усны төрлүүдийг ялгаж, мэдээлэлд (тоон болон зурган) тулгуурлан онцлогийг	1. Хуурай газрын усны төрлүүдийг ялган, дэлхийн томоохон гол, нууруудын тоон болон зурган мэдээлэл тулгуурлан онцлогийг нь тайлбарладаг.
4	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 7.4.4. Далай тэнгис, нуур, гол нь эргийн дагуух хүмүүсийн амьдрал ахуй, байгаль, нийгмийн орчинд нөлөөлж буйг жишээгээр тайлбарлах	1. Эргийн дагуух хүмүүсийн амьдрал ахуй, байгаль, нийгмийн орчинд нөлөөлөх эерэг болон сөрөг талуудыг жишээгээр тайлбарладаг.

Суралцахуйн үр дүн:

7.4.1. Сурагч усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг ялган тодорхойлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг усны төлөвд үндэслэн ялган тодорхойлдог	Усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг (ууршилт, конденсац, хур тунадас, нарны гэрэл) ялган нэрлэдэг	Усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг (ууршилт, конденсац, хур тунадас, мөнх цас, мөсөн гол, нарны гэрэл) ялган нэрлэдэг	Усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг (ууршилт, конденсац, хур тунадас, мөнх цас, мөсөн гол, нарны гэрэл) ялган тодорхойлдог	Усны эргэлтэд оролцох бүрэлдэхүүн хэсгүүдийг усны төлөвд үндэслэн (ууршилт, конденсац, хур тунадас, гүний ус, гадаргуугийн урсац, мөнх цас, мөсөн гол, нарны гэрэл) ялган ангилж тодорхойлдог

Суралцахуйн үр дүн:

7.4.2. Сурагч дэлхийн далайн хэсгүүдийг ялгаж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Дэлхийн далайн хэсгүүдийг ялган, хүйтэн ба дулаан урсгалыг газар зүйн зураг ашиглан нэрлэдэг	Дэлхийн далайн хэсгүүдийг (Энэтхэгийн далай, Атлантын далай, Номхон Далай) таних тэмдэг ашиглан уншиж, нэрлэдэг	Дэлхийн далайн хэсгүүдийг ялган, хүйтэн (Перу, Бенгал, Канар) эсвэл дулаан (Гольфстрийм, Номхон далай,) урсгал, томоохон буланг (Бенгалын, Мексикийн) газар зүйн зураг ашиглан нэрлэдэг	Дэлхийн далайн хэсгүүдийг ялган (Энэтхэгийн далай, Атлантын далай, Номхон Далай, томоохон тэнгис: Газар Дундын, Балтийн, булан: Бенгалын, Мексикийн, хойг: Скандинавын, арлуудыг: Гренландын, Мадагаскарын), хүйтэн (Перу, Бенгал, Баруун зүгийн салхины, Канар) ба дулаан (Гольфстрим) урсгал зэргийн байршлыг нь дасгалын зурагт тэмдэглэж, нэрлэдэг	Дэлхийн далайн хэсгүүдийг ялган (Энэтхэгийн далай, Атлантын далай, Номхон Далай, томоохон тэнгис: Газар Дундын, Мраморын, Балтийн, Норвегийн, Өмнөд Хятадын, булан: Бенгалын, Гудзоны, Мексикийн, хойг: Скандинавын, Балканы, арлуудыг: Гренландын, Мадагаскарын), хүйтэн (Перу, Бенгал, Баруун зүгийн салхины, Канар) ба дулаан (Гольфстрим, Өмнөд Пассат, Номхон далай, Хойд пассат) урсгал зэргийн байршлыг нь дасгалын зурагт тэмдэглэж, нэрлэдэг

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

7.4.3. Сурагч хуурай газрын усны төрлүүдийг ялгаж, мэдээлэлд (тоон болон зурган) тулгуурлан онцлогийг тайлбарлаж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Хуурай газрын усны төрлүүдийг ялган, дэлхийн томоохон гол, нууруудын тоон болон зурган мэдээлэл тулгуурлан онцлогийг нь тайлбарладаг.	- Хуурай газрын усны төрлүүдийг (гол, нуур, газар доорх ус, мөсөн гол) ялгадаг - Тоон болон зурган мэдээлэлд тулгуурлан гол мөрөн (Нил, Амазон), нуурын (Байгаль, Каспий) байршлыг нэрлэдэг	- Хуурай газрын усны төрлүүдийг (гол, нуур, газар доорх ус, мөсөн гол) ялгадаг - Тоон болон зурган мэдээлэлд тулгуурлан гол мөрөн (Нил, Амазон), нуурын (Байгаль, Каспий) онцлогийг дүрсэлдэг	- Хуурай газрын усны төрлүүдийг (гол, нуур, газар доорх ус, мөсөн гол) ялгадаг - Тоон болон зурган мэдээлэлд тулгуурлан гол мөрөн (Нил, Амазон, Ижил мөрөн, Хөх Мөрөн, Конго, Амар мөрөн зэрэг) (хамгийн урт, хамгийн их устай, олон улс орны хилийн зааг болдог, олон зүйл загас, ургамалтай г.м.), нуурын (Байгаль, Титикака, Каспий, Чад, Танганьика) онцлогийг (хамгийн өндөр оршдог, хамгийн шорвог, том талбайтай, цэнгэг устай, улирлаас хамаарч хэмжээ нь маш их өөрчлөгддөг, давстай, олон улс орны хилийн зааг болдог) нь дүрсэлдэг	- Хуурай газрын усны төрлүүдийг (гол, нуур, газар доорх ус, мөсөн гол) ялгадаг - Тоон болон зурган мэдээлэлд тулгуурлан гол мөрөн (Нил, Амазон, Ижил мөрөн, Хөх Мөрөн, Конго, Амар мөрөн зэрэг) (хамгийн урт, хамгийн их устай, олон улс орны хилийн зааг болдог, олон зүйл загас, ургамалтай г.м.), нуурын (Байгаль, Титикака, Каспий, Чад, Танганьика) онцлогийг (хамгийн өндөр оршдог, хамгийн шорвог, том талбайтай, цэнгэг устай, улирлаас хамаарч хэмжээ нь маш их өөрчлөгддөг, давстай, олон улс орны хилийн зааг болдог) нь тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

7.4.4. Сурагч далай тэнгис, нуур, гол нь эргийн дагуух хүмүүсийн амьдрал ахуй, байгаль, нийгмийн орчинд нөлөөлж буйг жишээгээр тайлбарлах тайлбарлаж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Эргийн дагуух хүмүүсийн амьдрал ахуй, байгаль, нийгмийн орчинд нөлөөлөх эерэг болон сөрөг талуудыг жишээгээр тайлбарладаг	Газар зүйн зураг ба баримтад тулгуурлан далайн эргийн дагуух хүмүүсийн ахуй амьдрал, эрхлэх аж ахуй, байгалийн гамшигт үзэгдэлд өртөж буй байдал зэргийг жишээгээр (Япон, Энэтхэг) тоочдог / нэрлэдэг	Газар зүйн зураг ба баримтад тулгуурлан далайн эргийн дагуух хүмүүсийн ахуй амьдрал, эрхлэх аж ахуй, байгалийн гамшигт үзэгдэлд өртөж буй байдал зэргийг жишээгээр (Япон, Энэтхэг) дүрсэлдэг	Газар зүйн зураг ба баримтад тулгуурлан далай, тэнгис, гол, нуурын эрэг дагуух хүмүүсийн амьдрал ахуй, байгаль (усан хангамж, гамшиг үзэгдэл, уур амьсгал), нийгмийн (усан тээвэр, усан хангамж, түүхэн хотууд) орчинд хэрхэн нөлөөлж буйг жишээгээр (Энэтхэг, Хятад, Бразил, Египет, Малайз, Шинэ Зеланд) дүрсэлдэг	Газар зүйн зураг ба баримтад тулгуурлан далай, тэнгис, гол, нуурын эрэг дагуух хүмүүсийн амьдрал ахуй, байгаль (усан хангамж, гамшиг үзэгдэл, уур амьсгал), нийгмийн (усан тээвэр, усан хангамж, түүхэн хотууд) орчинд хэрхэн нөлөөлж буйг жишээгээр (Энэтхэг, Хятад, Бразил, Египет, Малайз, Шинэ Зеланд) тайлбарладаг

1.2.5. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 5. ДЭЛХИЙН БАЙГАЛИЙН БҮС

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 7.5.1. байгалийн бүс дэх хөрс, ургамал, амьтны ялгааг харьцуулан	1. Хөрс, ургамал амьтан нь уур амьсгалын бүсээр ялгаатай болохыг тодорхойлодог

Суралцахуйн үр дүн:

7.5.1. Сурагч байгалийн бүс дэх хөрс, ургамал, амьтны ялгааг харьцуулан тодорхойлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Хөрс, ургамал амьтан нь уур амьсгалын бүсээр ялгаатай болохыг тодорхойлдог	Байгалийн бүс дэх хөрс, ургамал, амьтны ялгааг халуун ба сэрүүн, туйлын бүсээр ялгардгийг (амьтан, ургамлыг) нэрлэдэг.	Байгалийн бүс дэх хөрс, ургамал, амьтны ялгааг халуун ба сэрүүн, туйлын бүсээр ялгардгийг (амьтан, ургамлыг) дүрсэлдэг.	Байгалийн бүс дэх хөрс, ургамал, амьтны ялгааг халуун ба сэрүүн, туйлын бүсээр ялган харьцуулан (төрөл зүйлс, тоо хэмжээ зэргийг хүснэгтэн мэдээнд тулгуурлан) дүрсэлдэг.	Байгалийн бүс дэх хөрс, ургамал, амьтны ялгааг халуун ба сэрүүн, туйлын бүсээр ялган харьцуулж, онцлогийг нь (төрөл зүйлс, тоо хэмжээ зэргийг хүснэгтэн мэдээнд тулгуурлан) тодорхойлдог.

1.2.6. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 6. ГАЗАР ГАЗРЫН ХҮМҮҮС

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 7.6.1. Хүн ам байршлын онцлогийг газар зүйн зурагт тулгуурлан	1. Газар зүйн зураг ашиглан хүн амын байршлын онцлогийг (далай, томоохон гол, нуурын эрэг дагуу их байгааг, цөл, арктик зэрэг бага байгааг) тодорхойлдог.
2	Сурагч ... харьцуулж чаддаг болсон байна: 7.6.2. Баримтад тулгуурлан (хэл, соёл, эрхлэх аж ахуй) тив тивийн хүмүүсийн амьдралын онцлогийг	1. Тив тивийн хүмүүсийн хэл болон соёлын онцлогийг баримтад тулгуурлан харьцуулдаг. 2. Тив тивийн хүмүүсийн эрхлэх аж ахуйн онцлог нь уур амьсгалын бүсээр ялгардаг болохыг баримтад тулгуурлан харьцуулдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

7.6.1. Сурагч хүн ам байршлын онцлогийг газар зүйн зурагт тулгуурлан тодорхойлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Газар зүйн зураг ашиглан хүн амын байршлын онцлогийг (далай, томоохон гол, нуурын эрэг дагуу их байгааг, цөл, арктик зэрэг бага байгааг) тодорхойлдог	Хүн амын байршлын онцлог нь далайн эрэг, нуур, том голын дагуу их байгааг, Дэлхийн томоохон хотуудын (Бээжин, Токио, Нью-Йорк, Лондон, Парис, Бразилиа, Чикаго, Москва, Дубай) байршлыг нэрлэдэг	- Хүн амын байршлын онцлог нь далайн эрэг, нуур, том голын дагуу их байгааг, Дэлхийн томоохон хотуудын (Бээжин, Токио, Нью-Йорк, Лондон, Парис, Бразилиа, Чикаго, Москва, Дубай) байршлыг нэрлэдэг - Үүнд байгалийн нөхцөл нөлөөлж байгааг, (далай, томоохон гол, нуурын эрэг дагуу их байгааг, цөл, арктик зэрэг бага байгааг) холбон нэрлэдэг	- Хүн амын байршлын онцлог нь далайн эрэг, нуур, том голын дагуу их байгааг, Дэлхийн томоохон хотуудын (Бээжин, Токио, Нью-Йорк, Лондон, Парис, Бразилиа, Чикаго, Москва, Дубай) байршилтай холбон дүрсэлдэг - Үүнд байгалийн нөхцөл хэрхэн нөлөөлж байгааг холбон (далай, томоохон гол, нуурын эрэг дагуу их байгааг, цөл, арктик зэрэг бага байгааг) дүрсэлдэг	- Хүн амын байршлын онцлог нь далайн эрэг, нуур, том голын дагуу их байгааг, Дэлхийн томоохон хотуудын (Бээжин, Токио, Нью-Йорк, Лондон, Парис, Бразилиа, Чикаго, Москва, Дубай) байршилтай холбон дүрсэлдэг - Үүнд байгалийн нөхцөл хэрхэн нөлөөлж байгааг холбон (далай, томоохон гол, нуурын эрэг дагуу их байгааг, цөл, арктик зэрэг бага байгааг) тодорхойлдог

Суралцахуйн үр дүн:

7.6.2. Сурагч баримтад тулгуурлан (хэл, соёл, эрхлэх аж ахуй) тив тивийн хүмүүсийн амьдралын онцлогийг харьцуулж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Тив тивийн хүмүүсийн хэл болон соёлын онцлогийг баримтад тулгуурлан харьцуулдаг	Тив тивийн хүмүүсийн соёлын онцлогийг (шашин, ахуй) баримтад тулгуурлан нэрлэдэг	Тив тивийн хүмүүсийн хэл болон соёлын онцлогийг (хэл, шашин, эд, ахуй) баримтад тулгуурлан нэрлэдэг	Тив тивийн хүмүүсийн хэл болон соёлын онцлогийг (хэл, шашин, эд, ахуй) баримтад тулгуурлан дүрсэлдэг	Тив тивийн хүмүүсийн хэл болон соёлын онцлогийг (хэл, шашин, эд, ахуй) баримтад тулгуурлан ялгаж, харьцуулдаг
2. Тив тивийн хүмүүсийн эрхлэх аж ахуйн онцлог нь уур амьсгалын бүсээр ялгардаг болохыг баримтад тулгуурлан харьцуулдаг	Тив тивийн хүмүүсийн эрхлэх аж ахуйн онцлог (хөдөө аж ахуй: газар тариалан) нь уур амьсгалын бүсээр ялгардаг болохыг баримтад тулгуурлан нэрлэдэг	Тив тивийн хүмүүсийн эрхлэх аж ахуйн онцлог (хөдөө аж ахуй: газар тариалан, мал аж ахуй) нь уур амьсгалын бүсээр ялгардаг болохыг баримтад тулгуурлан нэрлэдэг	Тив тивийн хүмүүсийн эрхлэх аж ахуйн онцлог (хөдөө аж ахуй: газар тариалан, мал аж ахуй) нь уур амьсгалын бүсээр ялгардаг болохыг баримтад тулгуурлан дүрсэлдэг	Тив тивийн хүмүүсийн эрхлэх аж ахуйн онцлог (хөдөө аж ахуй: газар тариалан, мал аж ахуй) нь уур амьсгалын бүсээр ялгардаг болохыг баримтад тулгуурлан харьцуулдаг

ХОЁРДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

2.1. VIII АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	ГЗ8.1а. Монгол орны газар зүйн зургийн тусгагийн онцлогийг тайлбарлах ГЗ8.1б. Газар зүйн зургийг масштабаар нь ялган, онцлогийг тодорхойлох ГЗ8.1в. Газар орны үнэмлэхүй ба харьцангуй байрлалыг тодорхойлон харьцуулах ГЗ8.2а. Нарны тусгалын өнцөг, өдрийн үргэлжлэх хугацааны өргөргийн хамаарлыг тооцох ГЗ8.2б. Янз бүрийн газар орны цагийн ялгааг тодорхойлж, шалтгаан ба үр дагаврыг тайлбарлах ГЗ8.3а. Хүн амын тоон өөрчлөлтийг төрөл бүрийн аргаар дүрсэлж, шалтгааныг тайлбарлах ГЗ8.3б. Угсаатны онцлог ба газар зүйн тархалтыг ялган тодорхойлох	8.1. Монгол орны газар зүйн онцлог	Сурагч ... тодорхойлж сурсан байна: 8.1.1. Монгол орны Газар зүйн байрлалын онцлог (масштаб, харьцангуй ба үнэмлэхүй байрлал, давуу болон сул тал)-ийг янз бүрийн масштабтай Газар зүйн зураг ашиглаж
			Сурагч ... тооцоолдог болсон байна: 8.1.2. дэлхийн тэнхлэгээ эргэх ба нарыг тойрох хөдөлгөөн Монгол оронд хэрхэн нөлөөлдөг (нарны тусгалын өнцөг ба өргөргийн хамаарал, өдрийн үргэлжлэх хугацаа, цагийн бүсийн ялгаа)-ийг
			Сурагч ... зурагладаг болно: 8.1.3. Монгол орны хүн амын тоон өөрчлөлт ба угсаатны тархалтын онцлогийг газар зүйн зураг болон эх сурвалжид тулгуурлан
2	ГЗ8.4а. Монгол орны гадаргын хэв шинжийн ялгааг тодорхойлох ГЗ8.4б. Газар зүйн зураг ашиглан хотгор гүдгэрийн зүсэлт байгуулах ГЗ8.4в. Монгол орны ашигт малтмалын тархалтыг геологийн хөгжлийн түүхтэй холбон тайлбарлах ГЗ8.4г. Орон нутагтаа байгаа ашигт малтмал, газрын нөөцийн ашиглалтын талаар дүгнэх	8.2. Монгол орны геологийн хөгжил, гадарга, ашигт малтмал	Сурагч ... зүсэлт байгуулан тодорхойлж сурсан байна: 8.2.1. Монгол орны газрын гадаргын хэв шинж (уулсын тогтолцоо ба өндрийн ялгаа)-г газар зүйн зурагт
			Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.2.2. Монгол орны ашигт малтмалын тархалтыг геологийн хөгжлийн түүхтэй холбон
			Сурагч ... тодорхойлдог болсон байна: 8.2.3. орон нутгийнхаа мэдээлэлд тулгуурлан ашигт малтмал, газрын нөөцийн ашиглалтыг
3	ГЗ8.4д. Цаг агаарын зургийн таних тэмдэг ашиглан, төлөв байдлыг илэрхийлэх ГЗ8.4е. Уур амьсгалын элементүүдийн газар зүйн хуваарилалтыг улирлын ялгаагаар тайлбарлах	8.3. Монгол орны уур амьсгал	Сурагч ... тоймлон зурагладаг болно: 8.3.1. цаг агаарын төлөв байдлыг таних тэмдэг ашиглан
			Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.3.2. Монгол орны уур амьсгал, цаг агаарын үзэгдэл, өөрчлөлтийн газар зүйн хуваарилалтыг мэдээлэлд тулгуурлан

4	ГЗ8.4ж. Монгол орны усны нөөцөд нөлөөлсөн хүчин зүйлийг томоохон гол мөрөн нуурын жишээн дээр тодорхойлох	8.4. Монгол орны усны нөөц	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.4.1. Монгол орны усны нөөцийн Газар зүйн тархалтыг газар зүйн зураг ашиглан
	ГЗ8.4з. Монгол орны мөстлөг, цэвдэг ба газар доорх усны тархалт, өөрчлөлтийг тодорхойлон шалтгааныг тайлбарлах		Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.4.2. Монгол орны усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг жишээ баримтаар
5	ГЗ8.4и. Монгол орны хөрсний тархалтын зураг ашиглан голлох хэв шинжийн тархалт ба бүтцийг ялгах	8.5. Монгол орны байгалийн бүс, байгаль хамгаалал	Сурагч ... сэдэвчилсэн Газар зүйн зургаас хөрвүүлдэг болсон байна: 8.5.1. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн ялгаа үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлж
	ГЗ8.5а. Монгол орны голлох ургамал, амьтдын тархалтыг байгалийн бүс, бүслүүрээр ялгах ГЗ8.5б. Орон нутагтаа тулгараад байгаа байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг дэвшүүлэх		Сурагч ... санал дэвшүүлж чаддаг болсон байна: 8.5.2. Байгаль орчны тулгамдсан асуудлыг ялган таньж, шийдвэрлэх арга замыг тодорхой жишээн дээр

2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

2.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. МОНГОЛ ОРНЫ ГАЗАР ЗҮЙН ОНЦЛОГ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тодорхойлж сурсан байна: 8.1.1. Монгол орны газар зүйн байрлалын онцлог (масштаб, харьцангуй ба үнэмлэхүй байрлал, давуу болон сул тал)-ийг янз бүрийн масштабтай Газар зүйн зураг ашиглаж	1. Монгол орны газар зүйн үнэмлэхүй ба харьцангуй байрлалыг ялган тодорхойлдог
		2. Монгол орны газар зүйн зургийн зурагдах онцлогийг шинжилдэг
2	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: СҮД 8.1.2. Дэлхийн тэнхлэгээ эргэх ба нарыг тойрох хөдөлгөөн Монгол оронд хэрхэн нөлөөлдөг (нарны тусгалын өнцөг ба өргөргийн хамаарал, өдрийн үргэлжлэх хугацаа, цагийн бүсийн ялгаа)-ийг тооцоолдог болсон байна.	1. Улирал болон орших өргөргөөс хамаарч нарны тусгалын өнцөг, өдрийн үргэлжлэх хугацаа ялгаатай байдгийн шалтгааныг тайлбарладаг
3	Сурагч ... зурагладаг болно: 8.1.3. Монгол орны хүн амын тоон өөрчлөлт ба угсаатны тархалтын онцлогийг газар зүйн зураг болон эх сурвалжид тулгуурлан	1. Хүн амын тоон өөрчлөлт ба тархалтад нөлөөлөх хүчин зүйлсийг дүрслэлийн арга ашиглан тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

8.1.1. Сурагч нь Монгол орны Газар зүйн байрлалын онцлогийг янз бүрийн масштабтай Газар зүйн зураг ашиглан тодорхойлдог болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол орны газар зүйн үнэмлэхүй ба харьцангуй байрлалыг ялган тодорхойлдог	- Газар зүйн зураг ашиглахдаа шинжлэх ухааны бус энгийн үг хэллэг ашигладаг; - Дэлхийн газар зүйн зураг дээрээс Монгол орныг нэрлэдэг	- Газар зүйн зураг ашиглахдаа газар зүйн зарим нэр томъёо хэрэглэдэг; - Монгол орны харьцангуй байрлалыг хөрш улс орнуудтай харьцуулан тодорхойлдог	- Газар зүйн байрлалд хамааралтай нэр томъёо хэрэглэдэг; - Монгол орны 4 захын цэгийн солбицолд үндэслэн үнэмлэхүй байрлал ба өргөргийн дагуу сунаж тогтсон болохыг тодорхойлдог.	- Газар зүйн байрлалыг илэрхийлсэн шинжлэх ухааны оновчтой нэр томъёо хэрэглэдэг; - Монгол орны газар зүйн байрлалын онцлог (солбицол, өндөрлөг, далайгаас алслагдсан байдал, хиллэх Газар зүйн объект)-ийг тодорхойлдог
2. Монгол орны газар зүйн зургийн зурагдах онцлогийг шинжилдэг	- Монгол орны газар зүйн зургаас голдож зэргэдийн зурагдсан байдлыг ажиглан тодорхойлдог. - Тусгагийн үндсэн гурван төрлийг нэрлэдэг	Өргөргийн дагуу сунаж тогтсон дундад өргөргийн орон учраас огтолсон конус тусгагаар зурагддаг болохыг тайлбарладаг.	- Газар зүйн зургийн масштабаас хамааран зургийн агуулга, зориулалт өөрчлөгддөгийг тайлбарладаг - Тусгагийн үндсэн гурван төрлийг ялгадаг - Газар зүйн зураг дээр гажилттай, гажилтгүй зургийн хэсгийг тусгагаар ялгадаг	- Монгол орны Газар зүйн зурагт хэмжилтээс зэргэдийн нумын уртыг (45 ба 49 дүгээр зэргэд) тооцоолон харьцуулдаг. - Газар зүйн зураг дээр гажилтгүй шулууныг ялгадаг - Газар зүйн зурагт бодит зайн хэмжээнээс зөрүүтэй (их, бага) зурагддагийн шалтгааныг тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

8.1.2. Сурагч нь юмс үзэгдэл (нарны тусгалын өнцөг ба өргөргийн хамаарал, өдрийн үргэлжлэх хугацаа, цагийн бүсийн ялгаа, хүн амын тоон өөрчлөлт, угсаатны тархалт)-ийн Газар зүйн тархалт, өөрчлөлтийн онцлогийг зурган болон хүснэгтэн мэдээлэлд тулгуурлан тайлбарлаж чаддаг болсон байна:

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Улирал болон орших өргөргөөс хамаарч нарны тусгалын өнцөг, өдрийн үргэлжлэх хугацаа ялгаатай байдгийн шалтгааныг тайлбарладаг	Нар мандах, жаргах цагт үндэслэн өдрийн уртыг тооцоолдог.	- Өдрийн урт нь өргөрөг ба улирлаас хамааран ялгаатай байгааг Монгол орны хойд ба өмнөд хэсгийн жишээгээр баталдаг. - Уртрагийн зөрүүнд үндэслэн монгол орны цагийн зөрүүг тооцоолдог.	Жилийн хугацаанд нарны өндөр ба өдрийн үргэлжлэх хугацааны хамаарлыг шугаман график ба баганан диаграмм ашиглан дүгнэдэг.	- Үд дундын нарны тусгалын өнцгийг тооцоолж амьдрал ахуйдаа ашигладаг. - Цагийн бүсийн ялгарах шалтгаан ба үр дагаврыг жишээгээр тайлбарладаг

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

8.1.3. Монгол орны хүн амын тоон өөрчлөлт ба угсаатны тархалтын онцлогийг газар зүйн зураг болон эх сурвалжид тулгуурлан зурагладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Хүн амын тоон өөрчлөлт ба тархалтад нөлөөлөх хүчин зүйлсийг дүрслэлийн арга ашиглан тайлбарладаг	- Хүн амын нягтшилыг тооцоолдог - Хүн амын тоон өөрчлөлтийг шугаман графикаар дүрсэлдэг - Угсаатны зарим бүлгүүдийг нэрлэдэг	- Хамгийн их, бага нягтшилтай хүн амтай аймгийг нэрлэдэг - Шугаман графикаас хүн амын тоон өсөлтийн хандлагыг дүрсэлдэг - Зарим угсаатны бүлгүүдийг нэрлэж тархалтыг тодорхойлдог	- Хүн амын нягтшилыг тооцоолдог - Картограммын аргаар зурагдсан Монгол орны хүн амын нягтшилын зургаас мэдээлэл хөрвүүлдэг - Угсаатны бүлгүүдийн газар зүйн тархалтыг тодорхойлдог	- Хүн амын тоон өөрчлөлтийг харуулсан график /диаграмм/-ыг дүрсэлдэг - Хүн амын нягтшилыг тооцоолон, нягтшил их, бага байгаагийн шалтгааныг байгалийн орчинтой холбон тайлбарладаг - Угсаатны бүлгүүдийн онцлог ба газар зүйн тархалтын ялгааг тайлбарладаг

2.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. МОНГОЛ ОРНЫ ГЕОЛОГИЙН ХӨГЖИЛ, ГАДАРГА, АШИГТ МАЛТМАЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... зүсэлт байгуулан тодорхойлж сурсан байна: 8.2.1. Монгол орны газрын гадаргын хэв шинж (уулсын тогтолцоо ба өндрийн ялгаа)-г газар зүйн зурагт	1. Монгол орны гадаргын хэв шинжийг газар зүйн зураг ашиглан тодорхойлдог
		2. Хотгор гүдгэрийн зүсэлт байгуулдаг
2	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.2.2. Монгол орны ашигт малтмалын тархалтыг геологийн хөгжлийн түүхтэй холбон	1. Монгол орны геологийн хөгжлийн түүхийг гадаргын онцлогтой холбон тайлбарладаг
3	Сурагч ... тодорхойлдог болсон байна: 8.2.3. орон нутгийнхаа мэдээлэлд тулгуурлан ашигт малтмал, газрын нөөцийн ашиглалтыг	1. Ашигт малтмалын тархалтыг газар зүйн зураг ашиглан дүрсэлдэг

Суралцахуйн үр дүн:

8.2.1. Сурагч нь Монгол орны газрын гадаргын хэв шинж (уулсын тогтолцоо ба өндрийн ялгаа)-г газар зүйн зурагт гадаргын зүсэлт байгуулан тодорхойлж сурсан байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол орны гадаргын хэв шинжийг газар зүйн зураг ашиглан харьцуулан тодорхойлдог	- Уул болон тал газрыг ялган нэрлэдэг - Уулсын тогтолцооны заримыг нь ялган нэрлэдэг (Монгол Алтай, Говийн Алтай, Хөвсгөл, Хэнтий, Хангай, Хянган)	- Гадаргыг өндрийн түвшингөөр (өндөрлөг болон нам газраар) нь ялгаж тодорхойлдог - Монгол орны уулсын тогтолцоог (Монгол Алтай, Говийн Алтай, Хөвсгөл, Хэнтий, Хангай, Хянган) байршлаар нь ялган нэрлэдэг	- Гадаргыг өндрийн түвшингөөр нь (өндөр, дундаж өндөр, нам уулс, цав толгод, ухаа гүвээт ба тэгш тал) ангилдаг - Томоохон хэв шинжүүдийг (өндөр уулс, тэгш тал эсвэл хотгор газар) дэлхийн томоохон уул, тал, хотгор газрын хэмжээтэй (өндөртэй нь) харьцуулдаг - Уулсын тогтолцоо ба салбар уулсыг байршлаар нь харьцуулан тодорхойлдог	- Гадаргыг өндрийн түвшингөөр (өндөр, дундаж өндөр, нам уулс, цав толгод, ухаа гүвээт ба тэгш тал) нь ангилдаг - Томоохон хэв шинжүүдийг (өндөр уул, тэгш тал, хотгор газар) дэлхийн томоохон уул, тал, хотгор газрын хэмжээтэй (өндөртэй нь) харьцуулдаг - Уулсын тогтолцоо ба салбар уулсыг хэв шинж, хэлбэр, байршлаар нь харьцуулан тодорхойлдог
2. Хотгор гүдгэрийн зүсэлт байгуулдаг	Газар зүйн зургийн таних тэмдгүүдээс хаяалбар шугам, өнгөний шатлалыг ялган таньдаг.	Сонгосон зургийн хаяалбарын огтлолын өндрийн утгыг тодорхойлдог.	- Хотгор гүдгэрийн зүсэлтийг зааварчилгааны дагуу зөв дүрсэлдэг. - Фото, сансрын болон Газар зүйн зургуудыг ашиглан гадаргын хэлбэрийг тодорхойлон бичдэг.	- Байгуулсан зүсэлтдээ тулгуурлан гадаргын хэв шинжийг тодорхойлдог - Хаяалбар зураг ашиглан гадаргын хэлбэрийн загвар бүтээдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

8.2.2. Сурагч нь Монгол орны геологийн хөгжлийн түүхийг гадаргын хэв шинжтэй холбон тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол орны геологийн хөгжлийн түүхийг гадаргын онцлогтой холбон тайлбарладаг	Геологийн он тооллын эрин эсвэл галавыг ялган нэрлэдэг	- Геологийн он тооллын эрин, галавыг ялган нэрлэдэг - Монгол орны гадаргын өөрчлөлтийг геологийн цаг хугацаан дахь зарим үзэгдэл (уул тогтох хөдөлгөөн, нүүрсний орд, динозаврын мөхөл гм)-ээр холбон дүрсэлдэг	- Геологийн он тооллыг цаг хугацааны эрэмбэ дарааллаар ялгадаг - Монгол орны томоохон уул нуруудын (Хөвсгөлийн уулс, Хангай, Хэнтий, Алтайн нуруу) үүслийг геологийн цаг хугацаагаар нь ангилдаг	- Геологийн он тооллыг цаг хугацааны эрэмбэ дарааллаар ялгадаг - Монгол орны газрын гадаргын өөрчлөлт (уул, тал үүсэх)-ийг цаг хугацаа, уул үүслийн хөдөлгөөнтэй холбон тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

8.2.3. Сурагч нь Монгол орны ба нутаг орныхоо ашигт малтмалын тархалтыг тодорхойлдог болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Ашигт малтмалын тархалтыг газар зүйн зураг ашиглан дүрсэлдэг	Ашигт малтмалын орд газруудын тархалтыг газар зүйн зураг ашиглан байршлыг нь нэрлэдэг	- Монгол орны ашигт малтмалыг томоохон ордоор (Заамар, Оюу толгой, Эрдэнэт, Төмөртэй, Бор Өндөр, Бүрэн хаан, Таван толгой, Багануур, Тамсаг булаг г.м.) нь нэрлэдэг - Ашигт малтмалын орд газруудын тархалтыг газар зүйн зураг ашиглан байршлыг нь дүрсэлдэг	- Монгол орны ашигт малтмалыг төрөл эсвэл ордоор нь ангилдаг - Ашигт малтмалын орд газруудын тархалтыг газар зүйн зураг ашиглан дүрсэлдэг	- Монгол орны ашигт малтмалыг төрөл, ордоор (стратегийн ач холбогдолтой: алт Заамар, зэс Оюу толгой, Эрдэнэт, төмөр- Төмөртэй, металл бус: жонш- Бор Өндөр, фосфор- Бүрэн хаан, давс- Шүдэн уул, шатах ашигт малтмал: нүүрс- Таван толгой, Багануур, газрын тос-Тамсаг булаг, Зүүнбаян, шатах занар- Цагаан овоо г.м.) нь ялган ангилдаг - Ашигт малтмалын орд газруудын тархалтыг газар зүйн зураг ашиглан дүрсэлдэг

2.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. МОНГОЛ ОРНЫ УУР АМЬСГАЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тоймлон зурагладаг болно: 8.3.1. цаг агаарын төлөв байдлыг таних тэмдэг ашиглан	1. Цаг агаарын зургаас цаг агаарын төлөв байдлыг тодорхойлдог
2	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.3.2. Монгол орны уур амьсгал, цаг агаарын үзэгдэл өөрчлөлтийн газар зүйн хуваарилалтыг мэдээлэлд тулгуурлан	1. Монгол орны уур амьсгалын газар зүйн хуваарилалтыг сэдэвчилсэн газар зүйн зураг уншин дүгнэдэг

Суралцахуйн үр дүн:

8.3.1. Сурагч нь цаг агаарын төлөв байдлыг таних тэмдэг ашиглан зурагладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Цаг агаарын зургаас цаг агаарын төлөв байдлыг тодорхойлдог.	• Цаг агаар, уур амьсгалын ялгааг нэрлэдэг.	• Цаг агаарын зургийг таних тэмдгийн тусламжтай уншдаг.	• Цаг агаарын зураг ба мэдээллийг уншиж цаг агаарын төлөв байдлыг тодорхойлдог.	• Цаг агаарын мэдээний тоон үзүүлэлтийг ашиглан цаг агаарын зураг зохиодог.

Суралцахуйн үр дүн:

8.3.2. Сурагч нь Монгол орны уур амьсгалын Газар зүйн хуваарилалтыг мэдээлэлд тулгуурлан тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол орны уур амьсгалын Газар зүйн хуваарилалтыг сэдэвчилсэн газар зүйн зураг уншин дүгнэдэг.	• Уур амьсгалын элементүүдийг (температур, агаарын даралт, хур тунадасны хуваарилалт, салхи) нэрлэдэг	• Монгол орны уур амьсгалын онцлогийг 4 улирлаар (температур, агаарын даралт, хур тунадасны хуваарилалт, салхи) тодорхойлон бичдэг.	• Агаарын температур, жилийн нийлбэр цацраг, даралт, хур тунадасны сэдэвчилсэн газар зүйн зургаас тодорхой газар орны уур амьсгалын дүгнэн бичдэг.	• Монгол орны уур амьсгалын онцлогт нөлөөлсөн хүчин зүйлсийг (гадаргын өндөршилт, нарны цацрагийн хуваарилалт, байгалийн бүс, далай тэнгисээс алслагдсан байдал г.м.) дүгнэдэг.

2.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. МОНГОЛ ОРНЫ УСНЫ НӨӨЦ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.4.1. Монгол орны усны нөөцийн Газар зүйн тархалтыг газар зүйн зураг ашиглан	1. Монгол орны гадаргын болон гүний усны төрлүүдийн тархалтын зургийг уншиж дүгнэдэг
2	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 8.4.2. Монгол орны усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг жишээ баримтаар	1. Монгол орны усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг баримтад тулгуурлан тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

8.4.1. Сурагч нь Монгол орны усны нөөцийн төрлүүдийн тархалтыг тодорхойлдог болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол орны гадаргын болон гүний усны төрлүүдийн тархалтын зургийг уншиж дүгнэдэг.	- Усны нөөцийн төрлүүдийг нэрлэдэг - Ус зүйн газар зүйн зураг ашиглан ай сав эсвэл зарим томоохон гол, нуурыг (Орхон, Туул, Сэлэнгэ, Хэрлэн, Завхан; Увс, Хөвсгөл, Хар, Хар Ус, Буйр, Хяргас г.м.) нэрлэдэг	- Усны нөөцийн төрлүүдийг нэрлэдэг - Ус зүйн газар зүйн зураг ашиглан томоохон (Орхон, Туул, Сэлэнгэ, Хэрлэн, Онон Завхан, Ховд; Увс, Хөвсгөл, Хар, Хар Ус, Буйр, Хяргас г.м.) гол, нуурын тархалтыг уншиж тайлбарладаг	- Усны нөөцийн төрлүүдийг ялгадаг - Ус зүйн газар зүйн зураг ашиглан томоохон (Орхон, Туул, Сэлэнгэ, Хэрлэн, Онон Завхан, Ховд; Увс, Хөвсгөл, Хар, Хар Ус, Буйр, Хяргас г.м.) гол, нуурын тархалтыг дүрсэлж тайлбарладаг	- Усны нөөцийн төрлүүдийг ялган ангилдаг - Ус зүйн газар зүйн зураг ашиглан Номхон далай, Хойд мөсөн далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савын томоохон гол, нууруудын (Орхон, Туул, Сэлэнгэ, Хэрлэн, Онон Завхан, Ховд; Увс, Хөвсгөл, Хар, Хар Ус, Буйр, Хяргас г.м.) тархалтыг ялган учир шалтгааныг жишээ баримтаар дүгнэдэг

Суралцахуйн үр дүн:

8.4.2. Сурагч нь Монгол орны усны нөөцийг өөрчлөлтийн шалтгааныг жишээ, баримтаар тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол орны усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг баримтад тулгуурлан тайлбарладаг.	Мэдээлэлд тулгуурлан усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг нэрлэдэг	Мэдээлэлд тулгуурлан усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг байгаль эсвэл хүний (нийгэм, эдийн засаг) үйл ажиллагаатай холбон дүрсэлдэг	Мэдээлэлд тулгуурлан усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг байгаль эсвэл хүний (нийгэм, эдийн засаг) үйл ажиллагаатай холбон тайлбарладаг	Мэдээлэлд тулгуурлан усны нөөцийн өөрчлөлтийн шалтгааныг байгаль болон хүний (нийгэм, эдийн засаг) үйл ажиллагаатай холбон бодит жишээгээр тайлбарладаг

2.2.5. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 5. МОНГОЛ ОРНЫ БАЙГАЛИЙН БҮС, БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... сэдэвчилсэн Газар зүйн зургаас хөрвүүлдэг болсон байна: 8.5.1. Монгол орны байгалийн бүс бүслүүрийн ялгаа үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлж	1. Сэдэвчилсэн газар зүйн зургуудыг ашиглан байгалийн бүс, бүслүүрийн ялгааг Газар зүйн байрлал, гадаргын хэв шинж, уур амьсгалын нөхцөлтэй холбон тайлбарладаг
2	Сурагч ... санал дэвшүүлж чаддаг болсон байна: 8.5.2. Байгаль орчны тулгамдсан асуудлыг ялган таньж, шийдвэрлэх арга замыг тодорхой жишээн дээр	1. Бодит жишээнд тулгуурлан орон нутгийн ба Монгол орны хэмжээнд байгаль орчны тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг санал болгодог.

Суралцахуйн үр дүн:

8.5.1. Сурагч нь Монгол орны байгалийн бүс бүслүүрийн ялгааг сэдэвчилсэн газар зүйн зургаас хөрвүүлдэг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Сэдэвчилсэн газар зүйн зургуудыг ашиглан байгалийн бүс, бүслүүрийн ялгааг газар зүйн байрлал, гадаргын хэв шинж, уур амьсгалын нөхцөлтэй холбон тайлбарладаг	- Байгалийн бүс, бүслүүрийг нэрлэдэг - Хөрс, ургамал, амьтны тархалтыг нэрлэдэг	Монгол орны үндэсний атлас, фото зураг ашиглан ургамлын төрөл зүйл, нягтшилыг байгалийн бүс бүслүүрээр харьцуулдаг.	- Байгалийн нөхцөл ба тариалан эрхлэлтийн хамаарлыг тодорхойлдог - Байгалийн бүс, бүслүүр үүсэх шалтгааныг газар зүйн байрлал, газрын гадарга, уур амьсгал, ус зүйтэй холбон тайлбарладаг	- Байгалийн бүс, бүслүүр үүсэх шалтгааныг газрын гадарга, уур амьсгал, ус зүйтэй холбон тайлбарладаг - Байгалийн бүс, бүслүүрийн ялгаатай байдлыг хөрс, ургамал, амьтны тархалттай холбон тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

8.5.2. Сурагч нь байгаль орчны тулгамдсан асуудлыг ялган таньж, шийдвэрлэх арга замыг тодорхой жишээн дээр санал дэвшүүлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Бодит жишээнд тулгуурлан орон нутгийн ба Монгол орны хэмжээнд байгаль орчны тулгамдаж буй асуудлыг илрүүлж, шийдвэрлэх арга замыг санал болгодог	Байгаль орчны тулгамдаж буй асуудлуудыг орон нутгийн хэмжээнд нэрлэдэг	- Тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг ялгадаг. - Байгаль орчны мэдээллийн сангаас орон нутгийн хэмжээнд тулгамдсан асуудлуудыг тодорхойлдог.	Орон нутгийн тулгамдсан асуудлын шалтгаан, үр дагаврыг оюуны дүрслэлийн аргаар тодорхойлдог	- Байгаль орчны тулгамдаж буй асуудалтай холбоотой бодит жишээ, нотолгоог сонгодог - Санал болгож буй арга замын шалтгаан, үр дагаврыг жишээгээр тайлбарладаг

ГУРАВДУГААР БҮЛЭГ. IX АНГИ

3.1. IX АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	ГЗ9.1а. Юмс үзэгдлийн шинж чанарыг илэрхийлэх, дүрслэх, хэмжих, тооцох, дүгнэхдээ сэдэвчилсэн Газар зүйн зураг ашиглах ГЗ9.1б. Сэдэвчилсэн зургуудыг сонгон давхцуулах замаар байгаль нийгмийн юмс үзэгдлийн холбоо хамаарал, төлөв байдалд үнэлгээ өгөх ГЗ9.2а. Нар, сар, дэлхийн харилцан байрлалын үр дагаврыг туршилтаар нотолж, аргын ба билгийн тооллын учрыг тайлбарлах ГЗ9.2б. Нарны тусгал, өдрийн үргэлжлэх хугацаа нь нийгмийн амьдралд хэрхэн нөлөөлж байгааг жишээгээр тайлбарлах	9.1. Дэлхий ба гео орон зайн дүрслэл	Сурагч ... үнэлж сурсан байна: 9.1.1. Сэдэвчилсэн зургуудыг сонгон харьцуулж байгаль, нийгмийн юмс үзэгдлийн шинж чанар, төлөв байдлыг Сурагч ... тайлбарлаж сурсан байна: 9.1.2. Нар, сар, дэлхийн хөдөлгөөний үр дагаврыг нийгмийн амьдралын жишээгээр
2	ГЗ9.3а. Монгол орны хүн амын шилжих хөдөлгөөн, өөрчлөлтийн шалтгааныг байгалийн болон нийгмийн хүчин зүйлтэй холбон тайлбарлах ГЗ9.3б. Аймаг сумын хүн амын статистик ашиглан хүн амын нас хүйсийн суварга байгуулах, уншиж ашиглах дүгнэлт гаргах ГЗ9.3в. Монгол орны хот хөдөөгийн хүн амын бүтцийг диаграммаар дүрслэх ГЗ9.3г. Хотын ангилал, хотжилтыг ялган таних	9.2. Монгол Улсын хүн ам ба суурьшил	Сурагч ... тайлбарлаж сурсан байна: 9.2.1. Баримтад тулгуурлан хүн амын тоон өөрчлөлтийн орон зайн ялгаатай байдлыг байгаль, нийгмийн хүчин зүйлстэй холбон Сурагч ... ялган таниж сурсан байна: 9.2.2. Хот хөдөөгийн хүн амын бүтцийг харуулсан диаграммаас суурьшлын ангилалыг
3	ГЗ9.4а. Байгалийн нөхцөл, нөөц Монгол орны эдийн засагт хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах ГЗ9.4б. Монгол орны газрын нэгдмэл сан, газар ашиглалтын төрлүүдийг графикаар дүрслэх ГЗ9.4в. Монгол орны үйлдвэрийн хэв шинжийг ангилж, ялгаатай байгаагийн учрыг тайлбарлах	9.3. Монгол Улсын байгалийн нөхцөл нөөц, үйлдвэрлэлийн хэв шинж, газар ашиглалт	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 9.3.1. Үйлдвэрлэлийн ялгаатай хэв шинжийг байгалийн нөхцөл нөөцтэй холбон
4	ГЗ9.4г. Мэдээллийн эх сурвалж ашиглан ХАА-н үйлдвэрлэлийн бүтэц, байршилд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох	9.4. Монгол Улсын хөдөө аж ахуй	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 9.4.1. Баримтад тулгуурлан Монгол орны хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг байгалийн нөхцөл, нөөц, газар зүйн байрлал, газар ашиглалтын онцлогтой холбон

5	ГЗ9.4д. Статистик мэдээлэлд үндэслэн Монгол орны дэд бүтцийн онцлогийг дүрслэлийн аргаар илэрхийлж, дүгнэлт гаргах	9.5. Монгол Улсын дэд бүтэц	Сурагч ... дүгнэж чаддаг болсон байна: 9.5.1. Монгол орны дэд бүтцийн салбаруудын ангилал, байршил, гүйцэтгэх үүргийг мэдээлэлд тулгуурлан
6	ГЗ9.5а. Монгол орны эдийн засгийн бүсүүдийг байгалийн ба нийгэм эдийн засгийн онцлогоор нь харьцуулах ГЗ9.5б. Эдийн засгийн тодорхой бүс нутгийг сонгон, газар зүйн байрлал, хүн ам, аж үйлдвэр, онцлогийг тодорхойлох ГЗ9.5в. Тогтвортой хөгжлийн тулгуур ухагдахууныг судалж, нийгэмд тулгамдсан асуудлыг тодорхойлох	9.6. Монгол Улсын бүс нутаг	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 9.6.1. Монгол орны эдийн засгийн бүсүүдийн байрлал, хүн ам, аж үйлдвэрийн онцлогийг харьцуулан Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 9.6.2. Тогтвортой хөгжлийн үүднээс нийгэмд тулгамдсан асуудлыг жишээгээр

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

3.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ДЭЛХИЙ БА ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... үнэлж сурсан байна: 9.1.1. Сэдэвчилсэн зургуудыг сонгон харьцуулж байгаль, нийгмийн юмс үзэгдлийн шинж чанар, төлөв байдлыг	1. Сэдэвчилсэн зураг (Байр зүйн болон агаар сансрын зураг)-ийн таних тэмдэг, дүрслэлийн аргуудыг ялган тодорхойлох замаар байгаль, нийгмийн юмс үзэгдлийн шинж чанарыг үнэлдэг
2	Сурагч ... тайлбарлаж сурсан байна: 9.1.2. Нар, сар, дэлхийн хөдөлгөөний үр дагаварыг нийгмийн амьдралын жишээгээр	1. Нар сар дэлхийн хөдөлгөөн хүмүүсийн амьдрал аж ахуйд хэрхэн нөлөөлж буй хамаарлыг жишээгээр тайлбарладаг

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

9.1.1. Сурагч сэдэвчилсэн зургуудыг сонгон харьцуулж байгаль, нийгмийн юмс үзэгдлийн шинж чанар, төлөв байдлыг үнэлж сурсан байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Сэдэвчилсэн зураг (Байр зүйн болон агаар сансрын зураг)-ийн таних тэмдэг, дүрслэлийн аргуудыг ялган тодорхойлох замаар байгаль, нийгмийн юмс үзэгдлийн шинж чанарыг үнэлдэг	• Сэдэвчилсэн зураг (Байр зүйн болон агаар сансрын зураг)-ийн таних тэмдэг уншдаг.	• Сэдэвчилсэн зураг (Байр зүйн болон агаар сансрын зураг)-ийн таних тэмдэг, дүрслэлийн аргуудыг ялган тодорхойлдог	• Сэдэвчилсэн зураг (Байр зүйн болон агаар сансрын зураг)-ийн таних тэмдэг, дүрслэлийн аргуудыг ялган тодорхойлох замаар байгаль, эсвэл нийгмийн юмс үзэгдлийн шинж чанарыг үнэлдэг	• Сэдэвчилсэн зураг (Байр зүйн болон агаар сансрын зураг)-ийн таних тэмдэг, дүрслэлийн аргуудыг ялган тодорхойлох замаар байгаль, нийгмийн юмс үзэгдлийн шинж чанарыг үнэлдэг

Суралцахуйн үр дүн:

9.1.2. Сурагч нар, сар, дэлхийн хөдөлгөөний үр дагаврыг нийгмийн амьдралын жишээгээр тайлбарлаж сурсан байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Нар сар дэлхийн хөдөлгөөн хүмүүсийн амьдрал аж ахуйд хэрхэн нөлөөлж буй хамаарлыг жишээгээр тайлбарладаг	• Нар, сар, дэлхийн хөдөлгөөний ялгааг тодорхойлдог.	• Нар сар дэлхийн хөдөлгөөний үр дагаврыг арга билгийн тоололтой холбон харьцуулдаг.	• Нар сарны хөдөлгөөний дэлхийд үзүүлэх илрэлийг жишээгээр нотолдог.	• Нар сар дэлхийн хөдөлгөөний илрэл ба түүний үр дагаврыг оюуны зураглал хийж тайлбарладаг.

3.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. МОНГОЛ УЛСЫН ХҮН АМ БА СУУРЬШИЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тайлбарлаж сурсан байна: 9.2.1. Баримтад тулгуурлан хүн амын тоон өөрчлөлтийн орон зайн ялгаатай байдлыг байгаль, нийгмийн хүчин зүйлстэй холбон	1. Хүн амын статистик тоон мэдээлэл ашиглан хүн амын зарим үзүүлэлт (нягтшил, нас хүйсийн бүтэц, хот хөдөөгийн хүн амын тоо, бүтэц, г.м)-ийг график диаграммаар илэрхийлж, тайлбарладаг
		2. Хөдөлмөр эрхлэлтийн хуваарилагдсан байдлыг байгалийн нөхцөл нөөц, тухайн салбарын хөгжилтэй холбон тайлбарладаг
2	Сурагч ... ялган таниж сурсан байна: 9.2.2. Хот хөдөөгийн хүн амын бүтцийг харуулсан диаграммаас суурьшлын ангилалыг	1. Засаг захиргааны ялгаатай нэгж дэх хүн амын нутагшилтыг график, диаграммаар илэрхийлж хотын зэрэглэл ангиллыг ялгадаг

Суралцахуйн үр дүн:

9.2.1. Сурагч баримтад тулгуурлан хүн амын тоон өөрчлөлтийн орон зайн ялгаатай байдлыг байгаль, нийгмийн хүчин зүйлстэй холбон тайлбарлаж сурсан байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Хүн амын статистик тоон мэдээлэл ашиглан хүн амын зарим үзүүлэлт (нягтшил, нас хүйсийн бүтэц, хот хөдөөгийн хүн амын тоо, бүтэц, г.м)-ийг график диаграммаар илэрхийлж, тайлбарладаг	Хүн амын статистик тоон мэдээлэл цуглуулах арга замыг мэддэг	Хүн амын үзүүлэлтийг илэрхийлсэн график диаграммыг уншдаг	Хүн амын статистик тоон мэдээлэл ашиглан хүн амын үзүүлэлтийг график диаграммаар илэрхийлдэг	Хүн амын үзүүлэлтийг илэрхийлсэн график диаграммыг ашиглан дүгнэлт бичдэг.
2. Монгол орны хүн амын шилжих хөдөлгөөний төрөл, шалтгаан, хөдөлмөр эрхлэлтийг байгаль нийгмийн хүчин зүйлтэй холбон тайлбарладаг	- Хүн амын шилжих хөдөлгөөний жишээ гаргадаг. - Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг нэрлэдэг.	- Гаргасан жишээн дээр үндэслэн хүн амын шилжих хөдөлгөөний төрөл (Дотоод, гадаад, сайн дурын, албадан, байнгын, улирлын) шалтгааныг схемчлэн зурагладаг - Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд (хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдэл) –ийг тайлбарладаг.	- Монгол орны эсвэл орон нутгийн жишээн дээр хүн амын шилжих хөдөлгөөний статистик мэдээллээс татагч ба түлхэгч хүчин зүйлсийг илрүүлдэг. - Нутаг орныхоо хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцоолж, улсын дундажтай харьцуулан тайлбарладаг.	- Монгол орны эсвэл орон нутгийн жишээн дээр хүн амын шилжих хөдөлгөөний SWOT шинжилгээ хийдэг. - Хөдөлмөр эрхлэлтийн (хөдөлмөрийн насны хүн ам, ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдэл) аж ахуйн салбараар хуваарилагдсан байдлыг салбарын хөгжилтэй холбон тайлбарладаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

9.2.2. Сурагч хот хөдөөгийн хүн амын бүтцийг харуулсан диаграммаас суурьшлын ангилалыг ялган таниж сурсан байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Засаг захиргааны ялгаатай нэгж дэх хүн амын нутагшилтыг график, диаграммаар илэрхийлж хотын зэрэглэл ангиллыг ялгадаг	• Хотын зэрэглэл ангиллыг ялгадаг эсвэл хүн амын нутагшилтыг график диаграммаас уншдаг	• Засаг захиргааны аль нэг нэгж (нийслэл, дүүрэг, хороо, аймаг, сум, баг) дэх хүн амын нутагшилтыг график, диаграммаар илэрхийлдэг	• Засаг захиргааны аль нэг нэгж (нийслэл, дүүрэг, хороо, аймаг, сум, баг) дэх хүн амын нутагшилтыг график, диаграммаар илэрхийлж хотын зарим зэрэглэл ангиллыг ялгадаг	• Засаг захиргааны ялгаатай нэгж (нийслэл, дүүрэг, хороо, аймаг, сум, баг) дэх хүн амын нутагшилтыг график, диаграммаар илэрхийлж хотын зэрэглэл ангиллыг ялгадаг

3.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ НӨӨЦ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЭВ ШИНЖ, ГАЗАР АШИГЛАЛТ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тайлбарлаж чаддаг болсон байна: 9.3.1. Үйлдвэрлэлийн ялгаатай хэв шинжийг байгалийн нөхцөл, нөөцтэй холбон	1. Мэдээллийн эх сурвалж ашиглан аж үйлдвэрлэлийн салбарын бүтэц, байршилд нөлөөлөх хүчин зүйлийг харьцуулан тодорхойлдог
		2. Аж үйлдвэрийн салбарын түүхэн хөгжил, үүрэг, ач холбогдлыг байгалийн нөхцөл, нөөцтэй холбон тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

9.3.1. Сурагч үйлдвэрлэлийн ялгаатай хэв шинжийг байгалийн нөхцөл, нөөцтэй холбон тайлбарлаж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Мэдээллийн эх сурвалж ашиглан аж үйлдвэрлэлийн салбарын бүтэц, байршилд нөлөөлөх хүчин зүйлийг харьцуулан тодорхойлдог	• Аж үйлдвэрлэлийн салбарын бүтцийг нэрлэдэг	• Аж үйлдвэрлэлийн салбарын бүтэц (уул уурхай, эрчим хүч, боловсруулах: хөнгөн, хүнсний г.м.), байршилд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэдэг	• Аж үйлдвэрлэлийн салбарын бүтэц (уул уурхай, эрчим хүч, боловсруулах: хөнгөн, хүнсний г.м.), байршилд нөлөөлөх хүчин зүйлийг (байгалийн нөөц, нөхцөлтэй холбон) харьцуулдаг	• Аж үйлдвэрлэлийн салбарын бүтэц (уул уурхай, эрчим хүч, боловсруулах: хөнгөн, хүнсний г.м.), байршилд нөлөөлөх хүчин зүйлийг (байгалийн нөөц, нөхцөлтэй холбон) харьцуулан тодорхойлдог

2. Аж үйлдвэрийн салбарын түүхэн хөгжил, үүрэг, ач холбогдлыг байгалийн нөхцөл, нөөцтэй холбон тайлбарладаг	• Аж үйлдвэрийн салбарын ач холбогдлыг дүрсэлдэг / нэрлэдэг	• Аж үйлдвэрийн салбарын ач холбогдлыг (экспорт, импорт) байгалийн нөхцөл (рельеф, ус зүй, уур амьсгал), эсвэл нөөцтэй (ашигт малтмал, нөөцийн хэмжээ, стратегийн орд газар) холбон дүрсэлдэг	• Аж үйлдвэрийн салбарын үүрэг (хүн амын хүнсний бүтээгдэхүүнээр, хүнд болон хөнгөн үйлдвэрийг түүхий эд, нөөцөөр хангах), ач холбогдлыг (экспорт, импорт) байгалийн нөхцөл (рельеф, ус зүй, уур амьсгал), эсвэл нөөцтэй (ашигт малтмал, нөөцийн хэмжээ, стратегийн орд газар) холбон тайлбарладаг	• Аж үйлдвэрийн салбарын түүхэн хөгжил, үүрэг (хүн амын хүнсний бүтээгдэхүүнээр, хүнд болон хөнгөн үйлдвэрийг түүхий эд, нөөцөөр хангах), ач холбогдлыг (экспорт, импорт) байгалийн нөхцөл (рельеф, ус зүй, уур амьсгал), нөөцтэй (ашигт малтмал, нөөцийн хэмжээ, стратегийн орд газар) холбон тайлбарладаг
---	---	---	--	---

3.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ АЖ АХУЙ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 9.4.1. Баримтад тулгуурлан Монгол орны хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг байгалийн нөхцөл, нөөц, газар зүйн байрлал, газар ашиглалтын онцлогтой холбон	1. Монгол орны газрын нэгдмэл сангийн бүтэц, газар ашиглалтын онцлогийг баримтад тулгуурлан тодорхойлдог.
		2. МАА-н салбарын бүтэц, тоон өөрчлөлт, байршил, бүтээгдэхүүнийг байгалийн нөхцөл, бэлчээрийн даацтай холбон дүгнэдэг.
		3. Газар тариалангийн салбарын бүтэц, байршил, бүтээгдэхүүнийг байгалийн нөхцөлтэй холбон тодорхойлдог.

Суралцахуйн үр дүн:

9.4.1. Сурагч баримтад тулгуурлан Монгол орны хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг байгалийн нөхцөл, нөөц, газар зүйн байрлал, газар ашиглалтын онцлогтой холбон тодорхойлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол орны газрын нэгдмэл сангийн бүтэц, газар ашиглалтын онцлогийг баримтад тулгуурлан тодорхойлдог.	• Монгол Улсын газрын нэгдмэл сангийн ангиллыг нэрлэдэг	• Монгол орны газрын нэгдмэл сангийн бүтцийг баримтад (газрын нэгдмэл сангийн статистик мэдээлэл) тулгуурлан график, диаграммаар дүрсэлдэг.	• Монгол орны газрын нэгдмэл сангийн бүтэц, газар ашиглалтын онцлогийг баримтад (газрын нэгдмэл сангийн статистик мэдээлэл) тулгуурлан график, диаграммаар дүрсэлдэг.	• Монгол орны газрын нэгдмэл сангийн бүтэц, газар ашиглалтын онцлогийг баримтад (газрын нэгдмэл сангийн статистик мэдээлэл) тулгуурлан график, диаграммаар дүрсэлэн тодорхойлдог.
2. МAA-н салбарын бүтэц, тоон өөрчлөлт, байршил, бүтээгдэхүүнийг байгалийн нөхцөл, бэлчээрийн даацтай холбон дүгнэдэг.	• МAA-н салбарын бүтцийг ялган нэрлэдэг.	• МAA-н салбарын бүтцийн тоон өөрчлөлтийг график диаграммаар тодорхойлдог	• Уламжлалт ба эрчимжүүлсэн аж ахуйн онцлогийг гарц, ашиг шим ба зардал г.м үндэслэн харьцуулдаг. (SWOT анализ хийх)	• МAA-н салбарын бүтэц (Адуу, үхэр, тэмээ, хонь ямаа, эрчимжсэн фермерийн аж ахуй, туслах аж ахуй)-н байршлыг байгалийн нөхцөл, бэлчээрийн даацтай холбон дүгнэдэг
3. Газар тариалангийн салбарын бүтэц, байршил, бүтээгдэхүүнийг байгалийн нөхцөлтэй холбон тодорхойлдог.	• Газар тариалангийн салбарын бүтэц, бүтээгдэхүүнийг ялган нэрлэдэг	• Газар тариалангийн бүтэц тэдгээрийн бүсүүдийг Газар зүйн зурагт тодорхойлдог.	• Газар тариалангийн салбарын бүтэц, байршил, бүтээгдэхүүнийг аль нэг байгалийн нөхцөл (байгалийн бүс, тунадас температур, хөрс г.м)тэй холбон тодорхойлдог.	• Газар тариалангийн салбарын бүтэц, байршил, бүтээгдэхүүнийг байгалийн нөхцөл (байгалийн бүс, тунадас температур, хөрс г.м)тэй холбон тодорхойлдог.

3.2.5. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 5. МОНГОЛ УЛСЫН ДЭД БҮТЭЦ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... дүгнэж чаддаг болсон байна: 9.5.1. Монгол орны дэд бүтцийн салбаруудын ангилал, байршил, гүйцэтгэх үүргийг мэдээлэлд тулгуурлан	1. Зам тээврийн салбарын ангилал онцлогийг мэдээлэлд тулгуурлан ялган тодорхойлдог
		2. Үйлчилгээний салбарын бүтэц, гүйцэтгэх үүргийг тодорхойлж, дүгнэдэг

Суралцахуйн үр дүн:

9.5.1. Сурагч Монгол орны дэд бүтцийн салбаруудын ангилал, байршил, гүйцэтгэх үүргийг мэдээлэлд тулгуурлан дүгнэж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Зам тээврийн салбарын ангилал онцлогийг мэдээлэлд тулгуурлан ялган тодорхойлдог	•Зам тээврийн салбарын (авто, агаарын, төмөр, усан, ердийн хөсөг г.м) ангилал тус бүрийг ялган нэрлэдэг	•Зам тээврийн зарим салбарын (авто, агаарын, төмөр, усан, ердийн хөсөг г.м) ангилал тус бүрийг ялган тодорхойлдог	•Зам тээврийн салбарын (авто, агаарын, төмөр, усан, ердийн хөсөг г.м) ангилал тус бүрийг мэдээлэлд (ачаа, зорчигч тээвэр, ачаа эргэлт, зорчигч эргэлт) тулгуурлан ялган тодорхойлдог	•Зам тээврийн салбарын (авто, агаарын, төмөр, усан, ердийн хөсөг г.м)ангилал тус бүрийн онцлогийг мэдээлэлд (ачаа, зорчигч тээвэр, ачаа эргэлт, зорчигч эргэлт) тулгуурлан ялган тодорхойлдог
2. Үйлчилгээний салбарын бүтэц, гүйцэтгэх үүргийг тодорхойлж, дүгнэдэг	• Үйлчилгээний салбарын бүтэц (холбоо мэдээлэл технологи, аялал жуулчлал)-г ялган нэрлэдэг	• Үйлчилгээний аль нэг салбарын бүтэц (холбоо мэдээлэл технологи, аялал жуулчлал), гүйцэтгэх үүргийг дүрсэлдэг	•Үйлчилгээний салбарын бүтэц (холбоо мэдээлэл технологи, аялал жуулчлал), гүйцэтгэх үүргийг тайлбарладаг	• Үйлчилгээний салбарын бүтэц (холбоо мэдээлэл технологи, аялал жуулчлал), гүйцэтгэх үүргийг тодорхойлж, дүгнэдэг

3.2.6. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 6. МОНГОЛ УЛСЫН БҮС НУТАГ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 9.6.1. Сурагч нь эх сурвалжид тулгуурлан Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийн онцлогийг харьцуулан	1. Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийг байгалийн ба нийгэм эдийн засгийн онцлогоор нь харьцуулан тодорхойлдог
2	Сурагч ... тодорхойлж чаддаг болсон байна: 9.6.2. Сурагч нь тогтвортой хөгжлийн үүднээс нийгэмд тулгамдсан асуудлыг жишээгээр	1. Тогтвортой хөгжлийн үүднээс орон нутагтаа тулгамдсан асуудалд хандаж, олон нийтийг хамруулахад хувь нэмрээ оруулдаг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

9.6.1. Сурагч эх сурвалжид тулгуурлан Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийн онцлогийг харьцуулан тодорхойлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Монгол Улсын эдийн засгийн бүсүүдийг байгалийн ба нийгэм эдийн засгийн онцлогоор нь харьцуулан тодорхойлдог	• Монгол Улсын эдийн засгийн бүсүүд (Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатар) ийг ялган нэрлэдэг	• Монгол Улсын эдийн засгийн аль нэг бүсийн байгалийн эсвэл нийгэм эдийн засгийн онцлогийг нь дүрсэлдэг	• Монгол Улсын эдийн засгийн бүсүүд(Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатар)ийг байгалийн эсвэл нийгэм эдийн засгийн онцлогоор нь харьцуулан тодорхойлдог	• Монгол Улсын эдийн засгийн бүсүүд(Баруун, Зүүн, Хангайн, Төвийн, Улаанбаатар) ийг байгалийн ба нийгэм эдийн засгийн онцлогоор нь харьцуулан тодорхойлдог

Суралцахуйн үр дүн:

9.6.2. Сурагч нь тогтвортой хөгжлийн үүднээс нийгэмд тулгамдсан асуудлыг жишээгээр тодорхойлж чаддаг болсон байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Тогтвортой хөгжлийн үүднээс орон нутагтаа тулгамдсан асуудалд хандаж, олон нийтийг хамруулахад хувь нэмрээ оруулдаг.	• Хүрээлэн буй орчны бохирдлын төрлүүдийг орон нутгийн түвшинд нэрлэдэг.	• Олон улсын байгууллагуудаас гаргасан тогтвортой хөгжлийн тухай ойлголт, шийдвэрлэсэн жишээнүүдийг судалдаг.	• Орон нутагтаа тулгамдаж буй асуудал (хог хаягдал, хөрсний бохирдол, худаг ширгэх г.м)-ыг илрүүлж (кейс, баримт) мэдээлэл цуглуулдаг.	• Тодорхойлсон асуудлаа орон нутгийн удирдлага, холбогдох байгууллагатай хамтран гарч буй сөрөг үр дагаврыг хороо, багийн иргэд олон нийтэд сурталчлан таниулдаг.

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



ГАЗАР ЗҮЙ

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Дөрөвдүгээр бүлэг - X анги
Тавдугаар бүлэг - XI анги

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. Х АНГИ

4.1. Х АНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ, СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

№	Суралцахуйн зорилт	Үнэлгээний нэгж	Суралцахуйн үр дүн
1	10.1a. Газар зүйн зургийн тусгагийн төрлүүдийг ялгаж, гажилтыг тооцон, хэрэглэх зорилгодоо тохируулан сонгох 10.1б. Зурагзүйн дүрслэлийн аргуудын онцлогийг судлан газар зүйн төрөл бүрийн зураг уншихдаа ашиглах ба зураглах 10.2a. Байгаль нийгмийн юмс, үзэгдэл, өөрчлөлтийг судлахдаа Газар зүйн мэдээллийн систем (ГМС) хэрэглэх, жишээ гарган тайлбарлах 10.2б. Google Map, Google earth ашиглан сонгосон газар орныг судлах, тодорхойлох 10.3a. Нарны аймгийн шинж чанар, зүй тогтлыг дэлхийтэй харьцуулах 10.4a. Дэлхий гарагийн онцлог шинжийг судлан, хөдөлгөөний үр дагаврыг тайлбарлах 10.5a. Дэлхийн хүн амын тархалт, суурьшлийг өргөрөг, уртрагаар тодорхойлон, нөлөөлсөн хүчин зүйлсийг таамаглан нотлох 10.5б. Дэлхийн хүн амын суурьшлийн зурагт анализ хийж, шигүү ба сийрэг суудаг бүс нутгуудыг ялган, харьцуулж шалтгааныг тайлбарлах	1. Дэлхий ба гео орон зайн дүрслэл	Сурагч нь ... сонгодог байна. 10.1.1. Газар зүйн зургийн тусгаг, гажилт, дүрслэлийн аргуудыг харгалзан хэрэгцээт зургаа
			Сурагч нь ... мэдээлэл цуглуулдаг болно. 10.1.2. Сонгосон газар орны орон зай, цаг хугацааны мэдээллийг ГМС, Google Earth, Google Map ашиглан
			Сурагч нь ... харьцуулдаг болно. 10.1.3. Дэлхий гарагийн онцлог шинж чанарыг нарны аймгийн бусад гарагуудтай
			Сурагч нь ... жишээ баримтад тулгуурлан нотолдог болно. 10.1.4. Дэлхийн хүн амын шигүү ба сийрэг суурьшихад нөлөөлсөн хүчин зүйлийг (байгалийн ба нийгмийн)
2	10.6a. Дэлхийн дотоод үе давхаргын физик химийн шинж чанарыг нь ялган тус бүрийн онцлогийг тодорхойлох 10.6б. Чулуун мандлын найрлага, бүтцийг судлан эрдэс чулуулгийг ялган, онцлох шинжийг нь чулуулгийн эргэлттэй холбон тайлбарлах 10.6в. Дэлхийн дотоод хүчний үйл ажиллагаа, шалтгаан, үр дагаврыг тектоник хавтангийн хөдөлгөөнтэй холбон галт уулшил, газар хөдлөлтийн жишээн дээр тайлбарлах 10.6г. Рельефийн хэлбэрээр дэлхийн гадаад хүчний үйл ажиллагаа, төрлүүдийг тодорхойлох 10.6д. Геологийн гаралтай гамшигт үзэгдлийн газар зүйн тархалтыг тодорхойлон үр дагаврыг харьцуулах	2. Дэлхийн гадарга бүрэлдэх үйл явц	Сурагч нь ... дүрслэн тайлбарладаг болно. 10.2.1. Дэлхийн дотоод бүтэц, найрлага, эрдэс чулуулгийн гарал үүслийн ялгааг
			Сурагч нь ... жишээгээр нотолдог болно. 10.2.2. Дэлхийн дотоод ба гадаад хүчний үзэгдэл, үйл явц, үр дагаврыг

3	10.7а. Хийн мандлын найрлага, үе давхаргын зүй тогтлыг график, диаграммд үндэслэн тайлбарлах 10.7б. Дэлхийн гадарга дээрх нарны цацрагийн хуваарилалт ба өөрчлөлтийг төрлөөр нь ялгаж онцлогийг тодорхойлох 10.7в. Дэлхийн дулааны хуваарилалтыг агаарын температурын ялгаа ба өөрчлөлттэй холбон тайлбарлах 10.7г. Агаарын даралтын хуваарилалтын орон зайн болон улирлын ялгааг зураг ашиглан харьцуулж, тайлбарлах 10.7д. Агаарын ерөнхий орчил урсгал, үүсдэг шалтгаан, гарах үр дагаврыг даралтын бүслэг байдал ба дэлхийн хөдөлгөөлЦнтэй холбон тайлбарлах 10.7е. Цаг агаарын өөрчлөлтөд агаарын массын шилжилт ба фронт хэрхэн нөлөөлж байгааг синоптик зураг дээр тодорхойлон шалтгааныг тайлбарлах 10.7ж. Агаарын чийгийн үзүүлэлтийг тооцоолох замаар үүл үүсэх, тунадас унах нөхцөл бүрэлддэг шалтгааныг тодорхойлох 10.7з. Агаарын тунадасны газар зүйн хуваарилалтыг судлан орон зайн ба улирлын ялгаа үүсдэг шалтгааныг жишээн дээр тайлбарлах 10.7и. Дэлхий дээр уур амьсгалын ялгаа үүсэхэд нөлөөлдөг хүчин зүйлсийг тодорхойлж, дэлхийн дулаарлын үр дагаврыг эх сурвалж, тоо баримтад үндэслэн тайлбарлах	3. Өөрчлөгдөж буй уур амьсгал	Сурагч нь ... дүрслэн тайлбарладаг болно. 10.3.1. Хийн мандлын найрлага, үе давхарга, зүй тогтол, нарны цацрагийн хуваарилалтын ялгааг Сурагч нь ... харьцуулдаг болно. 10.3.2. Дэлхийн дулааны хуваарилалтын бүслэг байдлыг газар зүйн зураг ашиглан Сурагч нь ... шалтгааныг тайлбарладаг болно 10.3.3. Сэдэвчилсэн зураг ашиглан цаг агаарын үзэгдэл ба өөрчлөлтийн Сурагч нь ... баримтад тулгуурлан тайлбарладаг болно. 10.3.4. Уур амьсгалын өөрчлөлт, үр дагаврыг
4	10.8а. Усан мандлын бүрэлдэхүүн, шинж чанарыг тоо баримтад тулгуурлан дүгнэх 10.8б. Далайн усны шинж чанар, зүй тогтлыг газар зүйн зурагт тайлбарлах 10.8в. Далайн урсгалын төрлүүдийг ялган, байгаль нийгэмд үзүүлэх нөлөөг жишээгээр тайлбарлах 10.8г. Хуурай газрын усны төрлүүд (гол мөрөн, нуур, мөнх цас), тэдгээрийн тархалт, өөрчлөлт ба онцлогийг судлахдаа гео орон зайн дүрслэл ашиглан харьцуулах	4. Усны нөөц, хэрэглээ	Сурагч нь ... нотлон тайлбарладаг болно. 10.4.1. Усан мандлын бүрэлдэхүүнд хамаарах, далайн усны физик шинж чанарыг газар зүйн байрлалтай холбон баримтад тулгуурлан Сурагч нь ... анализ хийдэг болно. 10.4.2. Далайн усны бохирдол нь хүмүүсийн эрүүл мэнд, хүнс тэжээлийн хомсдолд нөлөөлж байгааг жишээн дээр тулгуурлан Сурагч нь ... тайлбарладаг болно. 10.4.3. Хуурай газрын усны төрлүүд, тархалт, өөрчлөлтийг мэдээлэлд тулгуурлан Сурагч нь ... графикаар илэрхийлж чаддаг болно. 10.4.4. Хүснэгтэн мэдээлэл ашиглан голын морфометрын үзүүлэлтийг

5	10.9а. Шим мандлын хүрээнд явагдах үзэгдэл, үйл явцыг газар зүйн үүднээс тайлбарлах	5. Дэлхийн амьдралын тархалт	Сурагч нь ... дүгнэдэг болно. 10.5.1. Шим мандлын хүрээнд явагдах үзэгдэл, үйл явцын харилцан хамаарлыг
	10.9б. Хөрсний бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлон, ялгаж, нөлөөлж буй хүчин зүйлсийн хамаарлыг гарган дүгнэлт хийх 10.10а. Газар зүйн бүрхэвчийн бүрэлдэхүүн түүнд явагдах үйл явцуудын зүй тогтлыг жишээгээр тайлбарлах 10.11а. Уур амьсгал, ургамал, хөрсний шинж чанар зэрэгт үндэслэн газар зүйн бүс, бүслүүрийг ялгах, бүрэлдэх шалтгааныг жишээгээр тайлбарлах		Сурагч нь ... нэгтгэн дүгнэдэг болно. 10.5.2. Уур амьсгал, ургамал, хөрсний шинж чанар, тархалтанд үндэслэн байгалийн бүс, бүслүүрийн ялгааг

4.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ ТУС БҮРИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮНГИЙН ШАЛГУУР, ГҮЙЦЭТГЭЛИЙН ТҮВШИН

4.2.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 1. ДЭЛХИЙ БА ГЕО ОРОН ЗАЙН ДҮРСЛЭЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	10.1.1. Газар зүйн зургийн тусгаг, гажилт, дүрслэлийн аргуудыг харгалзан хэрэгцээт зургаа сонгодог байна.	1. Хэрэглээндээ үндэслэн гажилт багатай зургийг сонгосон учрыг тайлбарладаг
		2. Зурагзүйн дүрслэлийн аргуудын онцлогийг судлан газар зүйн төрөл бүрийн зураг уншдаг.
2	10.1.2. Сонгосон газар орны орон зай, цаг хугацааны мэдээллийг ГМС, Google Earth, Google Map ашиглан цуглуулдаг болно.	1. Байгаль нийгмийн юмс, үзэгдэл, өөрчлөлтийг судлахдаа газар зүйн мэдээллийн систем (ГМС) хэрэглэн тайлбарладаг.
		2. Google Map, Google earth ашиглан сонгосон газар орныг судлан мэдээлэл цуглуулдаг.
3	10.1.3. Дэлхий гарагийн онцлог шинж чанарыг нарны аймгийн бусад гарагуудтай харьцуулдаг болно.	1. Нарны аймгийн шинж чанар, зүй тогтлыг дэлхийтэй харьцуулдаг.
		2. Дэлхий гарагийн онцлог шинжийг судлан, хөдөлгөөний үр дагаврыг тайлбарладаг.
4	10.1.4. Дэлхийн хүн амын шигүү ба сийрэг суурьшихад нөлөөлсөн хүчин зүйлийг (байгалийн ба нийгмийн) жишээ баримтад тулгуурлан нотлодог болно.	1. Дэлхийн хүн амын суурьшил тархалтын ялгааг өргөрөг уртраг, гадаргын өндөршил, байгалийн нөхцөлд үндэслэн шинжилдэг.

Суралцахуйн үр дүн:

10.1.1. Газар зүйн зургийн тусгааг, гажилт, дүрслэлийн аргуудыг харгалзан хэрэгцээт зургаа сонгодог байна.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Хэрэглээндээ үндэслэн гажилт багатай зургийг сонгосон учрыг тайлбарладаг	Аль нэгэн газар нутгийг судлахдаа сонгосон газар зүйн зургийнхаа тусгагийн төрлүүд, гажилтыг ялгадаг	Аль нэгэн газар нутгийг судлахдаа сонгосон газар зүйн зургийнхаа тусгагийн төрлүүд, (гажилт)-ын заримыг тайлбарладаг	Экватор, туйл, дундад өргөрөг (Монгол)-ийн нутгийг судлахдаа сонгосон газар зүйн зургийн тусгааг болон масштабыг тайлбарладаг	Экватор, туйл, дундад өргөрөг (жишээ болгож Монгол)-ийн нутгийг судлахдаа газар зүйн зургийг зөв сонгож, үндэслэлээ (тусгагийн төрлүүд (меркатор, гүүд, ламберт г.м), гажилт (өнцгийн, талбайн, шугаман) нэрлэн юунд хэрэглэхээ тайлбарладаг
2. Зурагзүйн дүрслэлийн аргуудын онцлогийг судлан газар зүйн төрөл бүрийн зураг уншдаг.	Газар зүйн зургуудийн таних тэмдгийг нэрлэдэг	- Газар зүйн сэдэвчилсэн зургуудын таних тэмдгийг харьцуулдаг. - Газар зүйн зургаас энгийн тодорхойлолтыг уншдаг.	- Газар зүйн сэдэвчилсэн зургуудын агуулгыг харьцуулдаг. - Нэмэлт мэдээллийн тусламжтай газар зүйн зургийг баяжуулж уншдаг.	- Газар зүйн сэдэвчилсэн зургуудын (засаг захиргааны, физик газар зүйн, уур амьсгалын, ургамлын, амьтны, байгалийн бүсийн, хөрсний, ТХГН-ийн гм) агуулга, хамрах нутаг, масштаб, таних тэмдгийг ашиглан харьцуулдаг. - Нэмэлт мэдээлэл (кейс, график, картодиаграмм, зурган, тоон ба хүснэгтэн мэдээлэл)-ийн тусламжтай газар зүйн энгийн тодорхойлолт бичдэг.

Суралцахуйн үр дүн:

10.1.2. Сонгосон газар орны орон зай, цаг хугацааны мэдээллийг ГМС, Google Earth, Google Map ашиглан цуглуулдаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Байгаль нийгмийн юмс, үзэгдэл, өөрчлөлтийг судлахдаа газар зүйн мэдээллийн систем (ГМС) хэрэглэн тайлбарладаг	ГМС-ийн өгөгдлийг уншдаг.	- ГМС-ийн өгөгдлийг уншдаг. - Давхаргуудыг нэрлэдэг	- ГМС-ийн өгөгдлийг уншдаг - Давхаргуудыг ялгадаг.	- ГМС-ийн өгөгдлийг растер, вектор дүрслэлээр ялгадаг. - Давхаргуудыг ялгаж тайлбарладаг.
2. Google Map, Google earth ашиглан сонгосон газар орныг судлан мэдээлэл цуглуулдаг.	Google Map, Google earth -ийн зураг ашиглан тухайн газар нутгийн солбицлын мэдээллийг уншдаг.	Google Map, Google earth -ийн зураг ашиглан тухайн газар нутгийн солбицол, гадаргын өндрийн мэдээлэл цуглуулдаг.	Google Map, Google earth -ийн зураг ашиглан тухайн газар нутгийн талаар мэдээлэл цуглуулдаг.	Google Map, Google earth -ийн зураг ашиглан тухайн газар нутгийн солбицол, гадаргын өндөр, усзүй, зам тээвэр, хотжилтын талаар мэдээлэл цуглуулж, тайлбарладаг

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Суралцахуйн үр дүн:

10.1.3. Дэлхий гарагийн онцлог шинж чанарыг нарны аймгийн бусад гарагуудтай харьцуулдаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Нарны аймгийн шинж чанар, зүй тогтлыг дэлхийтэй харьцуулдаг	• Нарны аймгийн гарагуудын байрлалыг харьцуулдаг	• Эх сурвалжаас түүвэрлэн нарны аймгийн гарагуудын шинж чанар (байрлал, хөдөлгөөн гм)-ыг харьцуулдаг.	• Эх сурвалжид тулгуурлан нарны аймгийн гарагуудын шинж чанар (байрлал, хэмжээ, хөдөлгөөн, нас, дагуултай эсэх гм)-ыг харьцуулдаг	• Эх сурвалжид (гарагуудын мэдээлэл бүхий хүснэгт, бүдүүвч) тулгуурлан нарны аймгийн гарагуудын шинж чанар (байрлал, хэмжээ, хөдөлгөөн, нас, дагуултай эсэх гм)-ыг дэлхийтэй харьцуулдаг
2. Дэлхий гарагийн онцлог шинжийг судлан, хөдөлгөөний үр дагаврыг тайлбарладаг	• Дэлхийн хөдөлгөөний (нарыг тойрох, тэнхлэгээ эргэх) аль нэгийг тайлбарладаг.	• Дэлхийн хөдөлгөөн (нарыг тойрох, тэнхлэгээ эргэх)-ийг тайлбарладаг.	• Дэлхийн хөдөлгөөнийг эх сурвалжид тулгуурлан (дэлхийн эргэлт, нарны тусгал, улирлын ялгаа, хэлбэр, хэмжээ) тайлбарладаг.	• Дэлхийн онцлог шинж (хэлбэр, хэмжээ, нягт, давхаргууд) болон хөдөлгөөн, үр дагаврыг эх сурвалжид тулгуурлан (дэлхийн эргэлт, нарны тусгал, улирлын ялгаа) тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

10.1.4. Дэлхийн хүн амын шигүү ба сийрэг суурьшихад нөлөөлсөн хүчин зүйлийг (байгалийн ба нийгмийн) жишээ баримтад тулгуурлан нотлодог болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Дэлхийн хүн амын суурьшил тархалтын ялгааг өргөрөг уртраг, гадаргын өндөршил, байгалийн нөхцөлд үндэслэн шинжилдэг.	• Дэлхийн хүн амын тархалт, суурьшлийн хэлбэрүүд ба түүнд нөлөөлж буй байгалийн хүчин зүйлсийг нэрлэдэг	• Дэлхийн хүн амын тархалт, суурьшлийг өргөрөг, уртрагаар тоймлон, нөлөөлж буй байгалийн хүчин зүйлсийг ялгадаг	• Дэлхийн хүн амын тархалт, суурьшлийн төвүүдийг (гадаргын өндөршил ба өргөрөг уртрагаар) тодорхойлж, нөлөөлж буй байгалийн эсвэл нийгмийн хүчин зүйлсийг харьцуулдаг.	• Дэлхийн хүн амын тархалт, суурьшлийн төвүүдийг (гадаргын өндөршил ба өргөрөг уртрагаар) тодорхойлдог. • Нөлөөлж буй байгалийн (байгалийн нөхцөл, нөөц) болон нийгмийн хүчин зүйлсийг ялгаж, тодорхой баримт жишээгээр харьцуулдаг.

4.2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 2. ДЭЛХИЙН ГАДАРГА БҮРЭЛДЭХ ҮЙЛ ЯВЦ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	10.2.1. Дэлхийн дотоод бүтэц, найрлага, эрдэс чулуулгийн гарал үүслийн ялгааг дүрслэн тайлбарладаг болно.	1. Дэлхийн дотоод бүтэц, үе, даралт, температур, найрлагын ялгааг дүрслэдэг.
		2. Эрдэс чулуулгийн шинж чанараас гарал үүслийг нь тогтоодог.
2	10.2.2. Дэлхийн дотоод ба гадаад хүчний үзэгдэл, үйл явц, үр дагаврыг жишээгээр нотолдог болно.	1. Дэлхийн дотоод хүчний үйл ажиллагаа, шалтгаан, үр дагаврыг дүгнэдэг.
		2. Рельефийн хэлбэрээр дэлхийн гадаад хүчний үйл ажиллагаа, төрлүүдийг тодорхойлдог.

Суралцахуйн үр дүн:

10.2.1. Дэлхийн дотоод бүтэц, найрлага, эрдэс чулуулгийн гарал үүслийн ялгааг дүрслэн тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Дэлхийн дотоод бүтэц, үе, даралт, температур, найрлагын ялгааг дүрслэдэг.	• Дэлхийн дотоод бүтцийн үе давхаргыг дүрсэлдэг.	• Дэлхийн дотоод бүтцийн үе давхаргын шинж чанарыг (даралт, температур, найрлагын аль нэгийг) дүрсэлдэг.	• Дэлхийн дотоод бүтцийн үе давхарга, даралт, температур, найрлагыг дүрсэлдэг.	• Дэлхийн дотоод бүтцийн үе давхарга бүрийн физик, химийн шинж чанарыг дүрсэлдэг. • Далай болон эх газрын үетэй харьцуулан тайлбарладаг.
2. Эрдэс чулуулгийн шинж чанараас гарал үүслийг нь тайлбарладаг.	• Эрдэс чулуулгийн шинж чанарыг нэрлэдэг.	• Эрдэс чулуулгийн шинж чанарыг ажиглаж, гарал үүсэлтэй нь холбож, тайлбарладаг.	• Эрдэс чулуулгийн шинж чанар (өнгө, хатуулаг, нягт гм)-ыг гарал үүсэлтэй нь холбож, тайлбарладаг.	• Эрдэс чулуулгийн шинж чанарыг чулуулгийн эргэлт, гарал үүсэлтэй нь холбож, орд газрын жишээгээр тайлбарладаг.

Суралцахуйн үр дүн

10.2.2. Дэлхийн дотоод ба гадаад хүчний үзэгдэл, үйл явц, үр дагаврыг жишээгээр нотолдог болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Дэлхийн дотоод хүчний үйл ажиллагаа, шалтгаан, үр дагаврыг хамаарлыг дүгнэдэг.	• Тектоник хавтангийн хөдөлгөөнийг галт уулшил, газар хөдлөлтийн жишээ баримт дээр тулгуурлан тайлбарладаг	• Дэлхийн дотоод хүчний үйл ажиллагаа, шалтгаан, үр дагаврыг галт уулшил, газар хөдлөлтийн жишээ баримт дээр тулгуурлан дүгнэдэг.	• Газар зүйн зураг ашиглан дэлхийн дотоод хүчний үйл ажиллагаа, шалтгаан, үр дагаврыг тектоник хавтангийн хөдөлгөөнтэй холбон дүгнэдэг.	• Газар зүйн зураг ашиглан дэлхийн дотоод хүчний үйл ажиллагаа, шалтгаан, үр дагаврыг тектоник хавтангийн хөдөлгөөн (галт уулшил, газар хөдлөлт)-тэй холбон шалтгаан, үр дагаврыг дүгнэдэг.

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

2. Рельефийн хэлбэрээр дэлхийн гадаад хүчний үйл ажиллагаа, төрлүүдийг тодорхойлдог.	• Элэгдэл, өгөршлийн жишээг нэрлэдэг.	• Газрын гадаргыг өөрчлөх гадаад хүчин зүйлсийг ялгадаг.	• Газрын гадаргыг өөрчлөх гадаад хүчин зүйлсийг рельефийн хэлбэрт үндэслэн ялгадаг. • Элэгдэл, өгөршлийн жишээгээр тайлбарладаг.	• Газрын гадаргыг өөрчлөх гадаад хүчин зүйлсийг рельефийн хэлбэрт (горст ба грабен) үндэслэн элэгдэл, өгөршлийн жишээгээр тодорхойлдог.
--	---------------------------------------	--	---	---

4.2.3. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 3. ӨӨРЧЛӨГДӨЖ БУЙ УУР АМЬСГАЛ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	10.3.1. Хийн мандлын найрлага, үе давхарга, зүй тогтол, нарны цацрагийн хуваарилалтын ялгааг дүрслэн тайлбарладаг болно.	1. Хийн мандлын найрлага, үе давхаргын зүй тогтлыг илрүүлдэг.
		2. Нарны цацрагийн төрлүүдийн газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг.
2	10.3.2. Дэлхийн дулааны хуваарилалтын бүслэг байдлыг газар зүйн зураг ашиглан харьцуулдаг болно	1. Дэлхийн дулааны хуваарилалтын газар зүйн шалтгааныг тайлбарладаг.
3	10.3.3. Сэдэвчилсэн зураг ашиглан цаг агаарын үзэгдэл ба өөрчлөлтийн шалтгааныг тайлбарладаг болно.	1. Агаарын ерөнхий орчил урсгал, агаарын даралтын газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг
4	10.3.4. Уур амьсгалын өөрчлөлт, үр дагаврыг баримтад тулгуурлан тайлбарладаг болно.	1. Цаг агаарын өөрчлөлтийн шалтгааныг агаарын массын шилжилт ба фронттой холбон тайлбарладаг.
		2. Агаарын чийгийн үзүүлэлтүүд, тунадасны газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг.
		3. Дэлхийн уур амьсгалын ялгаатай байдал, дэлхийн дулаарлын үр дагаврыг жишээгээр тайлбарладаг.

Суралцахуйн үр дүн:

10.3.1. Хийн мандлын найрлага, үе давхарга, зүй тогтол, нарны цацрагийн хуваарилалтын ялгааг дүрслэн тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Хийн мандлын найрлага, үе давхаргын зүй тогтлыг илрүүлдэг.	• Хий мандлын найрлага, физик шинж чанарыг нэрлэдэг	• Хий мандлын найрлага, физик шинж чанар, зүй тогтлыг илрүүлдэг.	• Хий мандлын физик шинж чанарт үндэслэн давхарга бүрийн зүй тогтлыг илрүүлдэг.	• Хий мандлын найрлага, физик шинж чанар, үзэгдлүүдэд тулгуурлан давхарга бүрийн шинж чанар, зүй тогтлыг харьцуулан тайлбарладаг
2. Нарны цацрагийн төрлүүдийн Газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг.	• Нарны цацрагийн төрлүүдийг нэрлэдэг	• Нарны цацрагийн төрлүүдийг ялгадаг	• Нарны цацрагийн төрлүүдийг ялгадаг • Газар зүйн хуваарилалтын онцлогийг тайлбарладаг	• Нарны цацрагийн төрлүүдийг ялгадаг • Газар зүйн хуваарилалтын онцлог болон шалтгааныг тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

10.3.2. Дэлхийн дулааны хуваарилалтын бүслэг байдлыг газар зүйн зураг ашиглан харьцуулдаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Дэлхийн дулааны хуваарилалтын газар зүйн шалтгааныг тайлбарладаг	• Дэлхийн дулааны хуваарилалтыг нарны цацрагийн хуваариалттай холбон тайлбарладаг	• Дэлхийн дулааны хуваарилалтыг агаарын температурын ялгаанд үндэслэн тайлбарладаг	• Дэлхийн дулааны хуваарилалтыг агаарын температурын ялгаа (1 ба 7-р сарын болон жилийн дундаж температурын зураг) -нд үндэслэн тайлбарладаг.	• Дэлхийн дулааны хуваарилалт (жилийн дундаж, улирлаар)-ыг агаарын температурын ялгаа (1 ба 7-р сарын болон жилийн дундаж температурын зураг) -нд үндэслэн агаарын температур өөрчлөгдөх Газар зүйн шалтгааныг тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

10.3.3. Сэдэвчилсэн зураг ашиглан цаг агаарын үзэгдэл ба өөрчлөлтийн шалтгааныг тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Агаарын ерөнхий орчил урсгал, агаарын даралтын газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг	• Агаарын даралтын газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг	• Агаарын ерөнхий орчил урсгал, агаарын даралтын хуваарилалтыг ялгадаг	• Агаарын ерөнхий орчил урсгал, агаарын даралтын газар зүйн хуваарилалтын хамаарлыг тайлбарладаг	• Агаарын ерөнхий орчил урсгал, агаарын даралтын газар зүйн хуваарилалтын ялгаатай байдлыг өөрчлөгдөх шалтгаан, үр дагаврын жишээгээр тайлбарладаг

Суралцахуйн үр дүн:

10.3.4. Уур амьсгалын өөрчлөлт, үр дагаврыг баримтад тулгуурлан тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
1. Цаг агаарын өөрчлөлтийн шалтгааныг агаарын массын шилжилт ба фронттой холбон тайлбарладаг.	• Цаг агаарын өөрчлөлтөд нөлөөлдөг агаарын массыг нэрлэдэг	• Цаг агаарын өөрчлөлтөд нөлөөлдөг агаарын массын шилжилтийг тайлбарладаг.	• Цаг агаарын өөрчлөлтөд нөлөөлдөг агаарын массын шилжилт эсвэл фронтын шинж чанар, зүй тогтлыг тайлбарладаг.	• Цаг агаарын өөрчлөлтөд нөлөөлдөг агаарын массын шилжилт ба фронтын шинж чанар, зүй тогтлын хамаарлыг тайлбарладаг.

2. Агаарын чийгийн үзүүлэлтүүд, тунадасны газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг	• Агаарын чийг, тунадасны газар зүйн хуваарилалтыг улирлаар ялгадаг	• Агаарын чийг, тунадасны газар зүйн хуваарилалтыг аль нэг улирлын жишээгээр тайлбарладаг	• Агаарын чийгийн үзүүлэлтүүд болон тунадасны газар зүйн хуваарилалтыг тайлбарладаг	• Агаарын чийгийн үзүүлэлтүүдийг тодорхойлж, агаарын тунадасны газар зүйн хуваарилалтыг орон зайн ба улирлын ялгаанд тулгуурлан жишээгээр тайлбарладаг
3. Дэлхийн уур амьсгалын ялгаатай байдал, дэлхийн дулаарлын үр дагаврыг жишээгээр тайлбарладаг	• Дэлхийн уур амьсгалын ялгаатай байдлыг нэрлэдэг	• Дэлхийн уур амьсгалын ялгаатай байдлыг жишээгээр ялган нэрлэдэг	• Дэлхийн уур амьсгалын ялгаатай байдлыг жишээн дээр тодорхойлдог • Дэлхийн дулаарлын үр дагаврыг баримттай тайлбарладаг	• Дэлхийн уур амьсгалын ялгаатай байдлыг жишээгээр тайлбарладаг • Дэлхийн дулаарлын үр дагаврыг тодорхой жишээгээр харьцуулан тайлбарладаг

4.2.4. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ 4. УСНЫ НӨӨЦ, ХЭРЭГЛЭЭ

№	Суралцахуйн үр дүн	Суралцахуйн үр дүнгийн шалгуур
1	10.4.1. Усан мандлын бүрэлдэхүүнд хамаарах, далайн усны физик шинж чанарыг газар зүйн байрлалтай холбон баримтанд тулгуурлан нотлон тайлбарладаг болно.	1.Усан мандлын бүрэлдэхүүнд хамаарах далайн усны физик шинж чанарыг газар зүйн байрлалтай холбон баримтанд тулгуурлан нотолдог.
2	10.4.2. Далайн усны бохирдол нь хүмүүсийн эрүүл мэнд, хүнс тэжээлийн хомсдолд нөлөөлж байгааг жишээн дээр тулгуурлан анализ хийдэг болно.	1.Далайн усны бохирдлын эх үүсвэрүүдийг ангилан, хүмүүсийн эрүүл мэнд, хүнс тэжээлийн хомсдолд нөлөөлж байгааг жишээн дээр тулгуурлан анализ хийдэг.
3	10.4.3. Хуурай газрын усны төрлүүд, тархалт, өөрчлөлтийг мэдээлэлд тулгуурлан тайлбарладаг болно	1.Хуурай газрын усны төрлүүдийн тархалт, өөрчлөлтийн мэдээлэлд тулгуурлан тайлбарладаг.
4	10.4.4. Хүснэгтэн мэдээлэл ашиглан голын морфометрын үзүүлэлтийг графикаар илэрхийлж чаддаг болно	1.Томоохон голын (ай сав, цутгал, усны зарцуулга, тахирлалтын коэффициент, нягтшил, хөндлөн огтлолын талбай, урсгалын хурд, голын ёроолын хурдас, усны баланс, гүн, унал хэвгий зэрэг үзүүлэлт бүхий) хүснэгтэн мэдээлэл ашиглан голын морфометрын үзүүлэлтийг графикаар илэрхийлдэг.

Суралцахуйн үр дүн:

10.4.1. Усан мандлын бүрэлдэхүүнд хамаарах, далайн усны физик шинж чанарыг газар зүйн байрлалтай холбон баримтанд тулгуурлан нотлон тайлбарладаг болно.

Гүйцэтгэлийн түвшний шалгуур

Суралцахуйн үр дүнгийн шалгуур	Гүйцэтгэлийн түвшин			
	I	II	III	IV
